

**ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр, Мягмар гараг*

*Хуралдааны тэмдэглэлийн агуулга*

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-5
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	6-34
<hr/>	
<i>1. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт</i>	6-25
<i>2. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах</i>	25-34

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы  
Хууль зүйн байнгын хорооны  
10 дугаар сарын 03-ны өдөр /Мягмар гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Хууль зүйн байнгын хорооны дарга Б.Энхбаяр ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 19 гишүүнээс 11 гишүүн хүрэлцэн ирж, 57.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 9 цаг 29 минутад Төрийн ордны “Жанжсин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Томилолттой: Л.Мөнхбаатар, Д.Цогтбаатар;

Чөлөөтэй: Н.Алтанхуяг, Э.Бат-Амгалан, Б.Дэлгэрсайхан, Х.Нямбаатар.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт**

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлтийн талаар Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Ш.Адьшаа, Д.Ганбат, Ц.Мөнх-Оргил, Ж.Сүхбаатар нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Г.Ганболд хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Б.Пүрэвдорж, Ц.Мөнх-Оргил, Ц.Мөнхцэцэг, Ж.Сүхбаатар, Ш.Раднаасэд, Д.Ганбат, Б.Энхбаяр нар үг хэлэв.

**Б.Энхбаяр:** 1.Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 9

Бүгд: 12

25.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар

хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

4.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

5.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11  
0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

6.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонголт хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг

зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

7.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгоглын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгоглын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

8.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгоглын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгоглын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

9.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгог зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонгоглын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонгоглын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 0  
Татгалзсан: 11  
Бүгд: 11

0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

10.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн "Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

11.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

12.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонголт явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно." гэж заасныг зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн саналыг дэмжжэ гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 1  
Татгалзсан: 10  
Бүгд: 11

9.1 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 10 цаг 52 минутад хэлэлцэж дуусав.*

***Хоёр.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах***

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, нэр дэвшигч, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгч Н.Батзориг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Д.Энхбат, мөн хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Г.Золжаргал, референт Э.Баттогтох, А.Наранцэцэг нар байлцав.

Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат, Б.Энх-Амгалан, Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нарын тавьсан асуултад Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Р.Онончимэг, нэр дэвшигч Н.Батзориг нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир, Б.Энхбаяр нар үг хэлэв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Сандаг-Очир Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

*Уг асуудлыг 11 цаг 29 минутад хэлэлцэж дуусав.*

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 19 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 68.4 хувийн ирцтэйгээр 11 цаг 29 минутад өндөрлөв.*

Тэмдэглэлтэй танилцсан:

ХУУЛЬ ЗҮЙН  
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Б.ЭНХБАЯР

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 10 дугаар сарын 03-ны өдөр,  
Мягмар гараг  
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”  
танхим  
9 цаг 29 минут.

### **ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Б.Энхбаяр:** Улсын Их Хурлын 2023 оны намрын ээлжит чуулганы 10 дугаар сарын 3-ны өдрийн ХЗБХ-ны хурал гишүүдийн олонх хүрэлцэн ирсэн учраас нээснийг мэдэгдье. Ирцийг та бүхэнд танилцуулъя. Энхбаяр гишүүн ирсэн байна, Адышаа гишүүн ирсэн байна, Бямбацогт гишүүн ирсэн байна, Ганбат гишүүн ирсэн байна, Мөнх-Оргил гишүүн ирсэн байна, Мөнхцэцэг гишүүн ирсэн байна, Пүрэвдорж гишүүн ирсэн байна, Раднаасэд гишүүн ирсэн байна, Сандаг-Очир гишүүн ирсэн байна, Сэргэлэн гишүүн ирсэн байна, Учрал гишүүн ирсэн байна.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя. 1 дүгээрт Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 дугаар дүгнэлт, Монгол Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хууль Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хууль, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль Авлигын эсрэг хуулийн зарим заалт Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх тухай асуудлыг хэлэлцэнэ. 2 дугаарт Монгол Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах асуудлыг хэлэлцэнэ. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байна уу? Алга байна. Хэлэлцэх асуудалдаа оръё.

**Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 05 дугаар дүгнэлт**

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцье. Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 82.2.1 Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь эсвэл зарим хэсгийг хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах гэж заасан байна. ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг гишүүдэд тараасан байгаа. Энэ асуудалтай холбоотойгоор Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Ганболд ҮХЦ-ийн 5 дугаар дүгнэлтийн талаар товч танилцуулга хийнэ. Ганболд гишүүнийг урьж байна.

**Г.Ганболд:** Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.2 дахь заалтын зарим хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэх Монгол Улсын ҮХЦ-ийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Их Хурлыг төлөөлөн оролцох итгэмжилсэн төлөөлөгчөөр Улсын Их Хурлын даргын 2022 оны 10 дугаар сарын 15-ны өдрийн 163 дугаар захирамжаар миний бие томилогдсон. Уг асуудлыг 22 оны 11 дүгээр сарын 4-ний өдөр хэлэлцэхээр 2 хоногийн өмнө буюу 22 оны 10 дугаар сарын 2-нд анх итгэмжлэгдсэн төлөөлөгч над дээр бичиг ирсэн. Үүний дагуу би Улсын Их Хурлын Хууль зүйн хэлтэс, Хууль зүйн байнгын хорооны хуульчидтай хамтран уг асуудлыг хойшлуулах хүсэлтийг явуулсан.

Тухайн үед бол Монгол Улсын төсөв хэлэлцэж байсан, төсвийн ажлын хэсэгт орсон энэ агуулгаараа бас материалтай танилцах ийм хугацаа өгөөч гэдэг байдлаар хойшлуулаад, үүний дагуу бол бид нар тайлбараа ҮХЦ-д

хүргүүлсэн. Энэний дараа үндсэндээ бүтэн жилийн хугацаанд зарим үед дунд суудлын хуралдаан товлох гэж байгаа талаар надтай байх эсэх талаар ярилцаж хугацаа товлож байсан. Гэсэн хэдий боловч хойшлогдож байгаад сая 23 оны 9 дүгээр сарын 26-ны өдөр хуралдах болсноо 24-ний өдөр надад мэдэгдсэн. Ингээд би 26-ны өдөр Швейцарын холбооны улсад олон улсын хуралд орохоор томилолт аваад онгоцны тийз бүртгэгдсэн байсан тул хуралдаанд оролцох боломжгүйгээ албан томилолттой байгаагаа Цэцэд мэдэгдсэн. Гэсэн хэдий боловч 26-ны өдөр хуралдаж шийдвэр гаргасан байна.

Уг маргаанд нийслэлийн БГД-ийн 3 дугаар хорооны оршин суугч иргэн Батмөнх гэдэг иргэн ҮХЦ-д хандах дараах агуулга бүхий мэдээлэл нэмэлт шаардлагыг хүргүүлсэн байгаа. Монгол Улсын төрийн байгуулалт нь Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Засгийн газар, шүүх гэсэн төрийн эрх мэдлийн институтэд хуваагддаг. Төрийн эрх мэдэл хуваарилах энэхүү зарчмын зорилго нь төрийн эрх мэдлийг засаглалын салаанд хуваарилж, тэдгээр нь бие биедээ харилцан хяналт тавих, тэнцвэрт байдлыг хангахад оршино. Нөгөөтээгүүр Монгол Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрхийг хязгаарлаж халдаж болохгүй. Гэтэл Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийг батлахдаа Ерөнхийлөгчийн бүрэн эрх болон шүүх эрх мэдлийн бие даасан хараат бус байдалд халдсан.

Тодруулбал уг хуулийн 29 дүгээр зүйлийн холбогдох заалтад Монгол Улсын Их Хурлаас ҮХЦ-ийн гишүүн, ШЕЗ-ийн гишүүн, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, Улсын Дээд шүүхийн шүүгчтэй танилцахдаа нэр дэвшигчийн сонсгол хийхээр заасан байгаа нь төрийн эрх мэдлийн хяналт харилцан тэнцвэрээ алдах, нэг талын бүрэн эрхэд халдаж нөлөөлөхөөр байна. Нэг.Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 5 дахь

хэсэгт ШЕЗ-ийн шүүгч дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг Монгол Улсын Их Хурал томилохоор заасан. Гэтэл нэр дэвшигчийн сонсгол хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан шүүгчийн хараат бус шүүхийн бие даасан байдлыг хангах ШЕЗ-ийн зорилгод үл нийцсэн нөлөөлөхүйц оролдлого юм.

Мөн Шүүхийн сахилгын хорооны шүүгчид дотроосоо сонгосон болон нээлттэй нэр дэвшсэн гишүүдийг томилохдоо нээлттэй сонсгол хийж байгаа нь Монгол Улсын Үндсэн хуулийн 40 дүгээр зүйлийн 6 дахь хэсэгт заасан хуульд заасан үндэслэл журмын дагуу шүүгчийг албан тушаалаас нь түдгэлзүүлэх, огцруулах болон сахилгын шийтгэл ноогдуулах Шүүхийн сахилгын хорооны бүрэн эрхэд халдсан нөлөөлж болохуйц үйлдэл юм. Иймд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ШЕЗ-ийн шүүгч бус гишүүн Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус гишүүн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг зөрчсөн байна.

2.Монгол Улсын үндсэн хуулийн 65 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт зааснаар ҮХЦ-ийн гишүүний 3-ыг Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүх санал болгосноор Улсын Их Хурал томилно. Гэтэл Улсын Их Хурал, Ерөнхийлөгч Улсын Дээд шүүхийн санал болгож байгаа хүмүүст нэр дэвшигчийн сонсгол хийж байгаа нь Улсын Их Хурал Ерөнхийлөгч болон Улсын Дээд шүүхийн нэр дэвшүүлэх бүрэн эрхэд шууд халдсан үйл бүрдэл юм. Учир нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2.3 дахь хэсэгт ҮХЦ түүний гишүүн гагцхүү Үндсэн хуульд захирагдаж аливаа байгууллага албан тушаалтнаас хараат бус байхаар зохицуулсан. Тиймээс нэр дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр ҮХЦ-ийн хараат бус байдалд нөлөөлөх боломж



байсаар байна. Угтаа бол Монгол Улсын Их Хурал, Ерөнхийлөгчид Улсын дээд шүүх нь тодорхой шалгуур үндэслэлээр сонгон авч санал болгож байгаа тул Монгол Улсын Их Хурал томилох эсэхийг шийдвэрлэх ёстой.

Мөн хуулийн дээрх зохицуулалттай холбогдуулан Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж гэж оруулсан нэмэлтийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан эрх бүхий этгээдийн санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэсэн өөрчлөлт оруулсан байгаа нь дээрх байдлаар Үндсэн хуулиар тогтоосон эрх бүхий этгээдийн бүрэн эрхийг зөрчсөн байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт ШЕЗ-өөс Улсын Дээд Шүүхийн шүүгчдийн Монгол Улсын Их Хуралд танилцуулах болохоос биш нэр дэвшигчийн сонсгол хийх талаар заагаагүй. Гэтэл Монгол Улсын Их Хурал бас л нэр дэвшигчийн сонсгол хийх нэрийдлээр танилцуулсан хүмүүсийг буцаах оролдлого хийх боломжтой болоод байна. Дээрхээс дүгнэвэл Монгол Улсын Их Хурал нь шүүх эрх мэдлийн байгууллага түүний гишүүдийг санал болгосон байгууллагын бүрэн эрхэд халдаж, сонсгол хийх зохицуулалтыг зөвшөөрөл гэсэн агуулгаар харж өөрөөсөө хараат байлгах дангаараа ноёрхох гэсэн зорилго бүхий хууль баталсан гэж үзэж байна. Ингэснээр шүүх эрх мэдэл нь хууль тогтоох эрх мэдлийн хууль бус ажиллагааг хянах бус хянуулах эрсдэл үүссэн байна.

Үүнээс үзэхэд Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын

хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол гэж заасан нь, түүнчлэн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсгийн энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан, санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус хуульчилсан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2, 64 дүгээр зүйлийн 2, 3, 65 дугаар зүйлийн нэг дэх хэсгийг зөрчжээ.

4. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад АТГ-ын дарга, дэд дарга гэж зааж үүнтэй уялдуулан Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт томилгооны сонсгол хийж, мөн зүйлийн 21.2 дахь хэсэгт томилгооны сонсгол хийж гэж хуульчилжээ. Ийнхүү нэр дэвшигчийн сонсгол явуулахаар зохицуулна, зохицуулсан нь АТГ-ын нэгдмэл бодлогыг саармагжуулах, бие даасан хараат бус байх зарчимд нь гаднын хэн нэгэн иргэн болон албан тушаалтны зүгээс нөлөөлөх боломжийг олгох, улмаар үүрэг чиглэл өгөх, амлалт авхуулах зэргээр томилогдсон нөхцөлд цаашид хуулийн дагуу хэвийн ажиллагаа ханган ажиллахад сөрөг нөлөө үзүүлэх оролдлого хийж хийх боломжтой байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн хуульд дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн гэснийг зөрчсөн байна гэж. Иймд дээрх шаардлагад дурдсан зохицуулалтуудыг

түдгэлзүүлж өгнө үү гэсэн ийм хүсэлтийг гаргасан.

Үүний дагуу бол бид бас Дээд шүүхэд тайлбар хүргүүлж, өөрсдөө заавал энэ Дээд шүүхийн Цэцийн дунд суудлын хуралдаанд биеэр орж тайлбар өгөхөө удаа дараа мэдэгдсэн боловч ингээд шүүх шийдвэр гаргасан байгаа. Энэ нэгэнт та бүхэнд тараагдсан учраас би өөрийн явуулсан тайлбарыг та бүхэн тараагдсан байгаа учраас энийг уншилгүйгээр хэрэв та бүхнийг асуувал хариульга гэдэг агуулгаар Цэцийн гаргасан шийдвэрийг та бүхэнд уншиж танилцуулъя. Дүгнэлтүүд нь бас та бүхэнд хүргэгдсэн байгаа. Тиймээс ҮХЦ та бүхэнд тараагдсан дээрх 7 үндэслэлийг үндэслэлийн дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн нэрийн өмнөөс дүгнэлт гаргах нь.

1. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан, санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүй тусгана гэж тус тус заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 64 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ҮХЦ, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна. 3 дахь хэсгийн ҮХЦ-ийн гишүүний хараат бус байдал нь Үндсэн хууль бусад хуулиар тогтоогдсон баталгаагаар хангагдана. 65 дугаар зүйлийн нэг дэх хэсгийн ҮХЦ 9 гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн 3-ыг Монгол Улсын Их Хурал, 3-ыг Ерөнхийлөгч, 3-ыг Улсын дээд шүүхийг

санал болгосноор Улсын Их Хурал 6 жилийн хугацаагаар томилно гэснийг тус тус зөрчсөн байна.

2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын 9-өөс доошгүй гэсэн хүсэлт гаргасан бол гэж заасныг танилцах, зөвшилцөх, танилцах гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн нэг дэх хэсгийн шүүгч хараат бус байж гагцхүү хуульд захирагдана, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн ШЕЗ-өөс Улсын дээд шүүхийн шүүгчдийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно, 56 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн УЕП, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч 6 жилийн хугацаагаар томилно гэснийг тус тус зөрчихсөн байна.

3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад ШЕЗ-ийн шүүгч бус гишүүн Шүүхийн сахилгын хорооны шүүгч бус бус гишүүн гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 49 дүгээр зүйлийн 1, 3, 5, 6, 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчөөгүй байна.

4. Авлигын эсрэг хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дахь хэсэгт томилгооны сонсгол хийж гэж тус тус заасан нь. Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад АТГ-ын дарга, дэд дарга гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн 1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн холбогдох заалтыг зөрчөөгүй байна.

5. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх заалтад ҮХЦ-ийн гишүүн 29.1.2 дахь заалтад танилцах зөвшилцөх

гэж Монгол Улсын ҮХЦ-ийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн нэг дэх хэсэгт нэр дэвшигчийн сонсгол хийж гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. Нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш тухайн тайлан, санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана гэж тус тус заасныг ҮХЦ Маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2023 оны 9 дүгээр сарын 27-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

Энэхүү дүгнэлтийг ҮХЦ-д маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дараагийн чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс 15 хоногийн дотор хэлэлцсэн хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай. Даргалагч Баясгалан, гишүүд Солонго, Туулхүү, Эрдэнэбулган, Гангабаатар гэсэн ийм ҮХЦ-ийн дүгнэлт гарсан байгаа.

**Б.Энхбаяр:** Ганболд гишүүнд баярлалаа. Хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулж Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуух асуулттай гишүүд нэрсээ өгнө үү. Сүхбаатар гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн, Бямбацогт гишүүнээр тасаллаа. Адьшаа гишүүн асуултаа асууя.

**Ш.Адьяа:** Би асуулт асуухгүй, зүгээр үг хэлчихье. Байгаа шүү дээ. Энэ шүүх эрх мэдлийн хуваарилалтын асуудлаар, шүүх бие даасан хараат байх асуудлаар Монгол Улсын ҮХЦ-д гомдол гаргасны дагуу Цэц шийдвэр гаргасан байна. Нийгмийн сэтгэл зүйд таарсан энэ Улсын Их Хурлын шийдвэр нь хэрэгжих үү, Монгол Улсын төрийн тогтолцооны бие даасан байдал харилцан хяналт тавих тэр тогтолцоо институтийн чинь Үндсэн хуульд заасан зарчим биелэгдэх үү гэдэг ийм сорилт дээр тулгарсан байна.

Би бол Монгол Улсын ҮХЦ-ийн дүгнэлтийг хүлээж авах ёстой гэж үзэж байгаа.

Монгол Улсын Их Хурал Шүүхийн тухай хуулийг баталсан. Энэ шүүхийн тухай хуульд шүүх эрх мэдэл, шүүх бие даасан, шүүх хараат бус байх энэ зарчим бол энэ хуулиар алдагдсан гэж удаа дараа би ярьж байгаа. Шүүх эрх мэдэл өнөөдөр хууль тогтоох эрх мэдлийн хараанд авч ирсэн энэ зохицуулалтыг Улсын Их Хурал хийсэн гэж ийм итгэл үнэмшилтэй байдаг. ШЕЗ, Шүүхийн сахилгын хорооны хараат бус гишүүдийг томилох асуудалд Улсын Их Хурал энэ эрх мэдлийг өөртөө авч ирсэн. Улсын Их Хурлын нэг гишүүн ахалж томилгооны сонсгол хийж сонгон шалгаруулалт зарладаг энэ хууль эрх зүйг энэ тогтолцоог энэ хуулиар бид баталсан. Энэ дээр би маш эсрэг байр суурьтай байсан. Түүний чинь үр дүн өнөөдөр гарч байгаа гэж би ойлгож байгаа. Улсын Их Хурал бол хууль баталдаг, хуулийн хэрэгжилтэд хяналт тавьдаг ийм үүрэгтэй. Бид өнөөдөр Шүүх эрх мэдлийн ерөнхий зөвлөлийн, сахилгын хорооны, Үндсэн хуулийн институтийн хүмүүсийг томилдог энэ асуудлаа бол бид эргэж харах ёстой. Энэ Үндсэн хуулийн хямрал руу ч оруулж байгаа.

Өнөөдөр ҮХЦ-д маш их муу муухай юм байгаа үнэн. Энэ ҮХЦ-ийн тухай хуульд өөрчлөлт оруулна гэж ярьсаар байгаад энэ парламент бүрэн эрхийнхээ хугацааг дуусах гэж байна. Тэгэхдээ бид нар энэ төрийн эрх мэдлийн хуваарилалтын зарчим, шүүх бие даасан хараат байх, Ерөнхийлөгчийн институтийн эрх мэдэл, хууль тогтоох эрх мэдэл, шүүх эрх мэдлийн бүрэн эрхэд халдсан ийм асуудал гэж ойлгож байгаа. Цэцийн энэ эрх баригчдын даалгавраар хэн нэгэн улс төрийн бодлогоор шийдвэр гаргахдаа бид эвлэрэхгүй энийг байнга шүүмжилж ирдэг. Тэгэхдээ энэ Их Хурал тэр Ерөнхийлөгчийн бүрэн эрх, Улсын Их Хурлын бүрэн эрх, тэгэхдээ энд ганцхан асуудал би энд сэтгэл дундуур байна. Монгол Улсын ҮХЦ өөрийнхөө эрх мэдэлтэй холбоотой өөрийнх нь

томилогдох, сонгогдох хүмүүстэй холбоотой энэ асуудлыг ҮХЦ шийдэх хэлэлцэх эрх зүйн үндэс байна уу, байхгүй юу гэдэг асуудлыг өнөөдөр хуулийн хүрээнд бас судалж энэ асуудлыг бас хууль зүйн хувьд шийдэх ёстой гэж бодож байгаа.

Өнөөдөр нийгэм, парламентын энэ засаглалын, ардчилсан парламентын засаглалын энэ гол зарчим бол томилогдох, сонгогдох энэ хүмүүсийг иргэд олон түмэнд нээлттэй байлгах энэ зарчмыг баримтлаад явж байгаа нь олон улсын парламентын жишиг гэж ойлгож явж байгаа. Гэтэл энэ асуудал чинь Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалтуудтай зөрчилдсөн гэдэг ойлголтыг энэ Улсын Их Хурал хүлээж авах ёстой, хүлээж авах ёстой. Тэрнээс биш Цэц муу муухай, Цэц хууль зөрчдөг гэдэг энэ асуудлаас нийгмийн сэтгэл зүй ийм байна гэдэг үүднээс бид Үндсэн хуулийн хуулийг зөрчсөн энэ асуудлыг энэ Улсын Их Хурал.../минут дуусав/

**Б.Энхбаяр:** Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Энэ ийм хариуцлагатай асуудалд Улсын Их Хурлаас томилогдсон итгэмжлэгч итгэмжлэн томилогдсон манай гишүүнийг яагаад оролцуулалгүй шийдсэн бэ? Энэ чинь Улсын Их Хуралд хандаж байгаа хандлага чинь ямар байдалд байна вэ гэдгээ эндээс дүгнэж болох юм. Улсын Их Хурал чинь өөрөө ард түмний төлөөлөл шүү дээ. Тэр Үндсэн хуулийн хамгийн эхэнд нь л байгаа байх. Төрийн бүх эрх мэдэл ард түмний гарт байна л гээд ингэчихсэн байгаа. Төр гэдэг чинь өөрөө харилцан тэнцвэртэй 3 зүйлээс л бүрдэнэ шүү дээ. Гүйцэтгэх засаглал, хууль тогтоох засаглал, шүүх засаглал. Энэ орж ирж байгаа нэр дэвшигч нар бол өөрсдөө яг тэр албан тушаалтан тэр ажил үүрэг гүйцэтгэгч болчхож, болоогүй байна шүү дээ. Тэрийг яагаад ард түмэн мэдэх эрхгүй юм бэ? Ямар хүмүүс явуулж байгааг энэ олон түмэн Улсын Их Хурал нь яагаад

мэдэхгүй болчхов. Энэний цаана юу нуугдаж байна вэ? Энэ дүгнэлттэй холбогдоод үүний үр дагавар нь ямар байх юм бол? Энийг бас би итгэмжилсэн төлөөлөгчөөсөө асуумаар байна.

Тэгээд энэ ҮХЦ маань өнөөдөр Үндсэн хуулийг хулгайлчхаад Үндсэн хуулийн манаачийнхаа үүргийг гүйцэтгэж чадаагүй ингэж явчхаад өнөөдөр Үндсэн хуулийн нэрийн өмнөөс гэж ингэж дүгнэлт гаргах эрхтэй юу? Улсын Их Хурал бол Улсын Их Хурал биш болсон шүү дээ. Хууль тогтоохыг ҮХЦ хийчихдэг, тэр Үндсэн хуулийн хамгийн суурь зарчмыг байхгүй болгочихсон шүү дээ. Өнөөдрийн гарч байгаа хамаг хулгай, луйвар бүх зүйл бол тэрнээс л эхтэй шүү дээ. Бид нар юмыг томоор нь харах хэрэгтэй. Энэ систем энэ бүх юмыг чинь дүр эсгэсэн нэр төдий л болгож ингэж өгч байгаа байхгүй юу. Тэгээд энэ хэд маань бүүр хэтэрхий даварчихсан, Монголын ард түмнийг хүндэтгэхгүй байна шүү дээ. Яг тэр Үндсэн хуулийнхаа суурь зарчмыг Үндсэн хууль дээрээ байхгүй болгочихсон ийм зүйл ажлыг хийчхээд дараа нь энэ маягаар ингээд хандаад байгаа нь бол арай хэтрэх нь хэтэрсэн байна. Тэгээд энэ ҮХЦ-ийн энэ дүгнэлт гаргасан энэ гишүүдийг шалгах ёстой байгууллагаар нь шалгуулах нь зөв болов уу. Яагаад ингээд ийм зүйл хийгээд байдаг юм бэ? Энэ ард түмнийг яаж ингэж үгүйсгэж чадаж байна вэ? Яагаад хэн гэдэг хүн ямар албан тушаалд очиж байгаа, ямар хүнийг томилж явуулж байгаагаа, нэр дэвшигчийг нь яагаад Монголын ард түмэн танилцаж болохгүй гэж байгаа юм бэ? Тэр мэдэх эрхийг нь яагаад хангахгүй гэж байгаа юм бэ?

Энэ цаашаа маш муу үр дагавартай гэж би ойлгож байна. Бид нар айна, ичнэ гэдэг зүйл байхгүй болчихсон байна. Энэ бүх юмыг давраах энэ байдлыг бий болгосон бол өнөөдрийн энэ Улсын Их Хурал өнөөдрийн эрх баригчид шүү дээ. Ийм ардчилсан улс орон гэж байхгүй гэж би ойлгож байна. Манай

итгэмжилсэн төлөөлөгч юу гэж бодож байна вэ?

**Б.Энхбаяр:** Ганболд гишүүн асуултад хариулъя.

**Г.Ганболд:** Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр жилийн өмнө томилогдсон. Ер нь бол Цэц хуралдаан зарлахдаа бол ер нь надад мэдэгдсэн 2, 3 удаагийн хурал зарлахдаа ер нь урьд өдөр нь л мэдэгддэг юм байна лээ. Яг сүүлийн би эхний хуралдаанууд дээр нь бол өөрөө тайлбар өгөөд зайлшгүй өөрийн биеэр оролцох ёстой гэдгээ илэрхийлсэн. Сая хуралдаан 26-нд хуралдаан зарлахдаа 25-нд надад бичиг ирсэн. 26-нд хуралдахаар байна гэж. Эх хувиараа ирээгүй Их Хурлын Тамгын газар чухам ирснийг нь би мэдэхгүй байна. Туслахаар дамжуулж ирсэн. Би 26-нд энэ олон улсын хуралд явахаар билет бичигдчихсэн байсан. Тэр агуулгаараа бол оролцох боломжгүй гэдгээ илэрхийлсэн албан бичиг явуулсан.

Гэтэл энийг хийсэн байна, хуралдаад шийдвэрийг нь гаргажээ. Эндээс ямар үр дагавар гарах вэ гэж та уншсан байх. Энд бол анх ямар маргаан үүсгэсэн юм гэхээр зэрэг ҮХЦ-ийн гишүүн зөвхөн АТГ-ын дарга, дэд даргыг томилохдоо томилгооны сонсгол хийхийн эсрэг ийм. Үүнийх нь дагуу бид нар бол энэ ХЗБХ-ны хуульчидтай хамтраад тайлбараа хүргүүлсэн. Үүний дараа дахиж нэхэмжлэлийн шаардлагаа нэмэгдүүлээд Дээд шүүхийн шүүгчид, ШЕЗ-ийн болон Шүүхийн сахилгын хорооны бүрэлдэхүүн дээр нь Ерөнхий прокурор, орлогч прокуроруудыг томилоход сонсгол хийх нь боломжгүй гэсэн ийм байдлаар өгсөн. Саяын дүгнэлт Цэцийн дүгнэлтээр бол АТГ-ын дарга болон дэд дарга ШЕЗ-ийн шүүгч бус гишүүдийг томилоход бол энэ сонсгол хийхэд бол ямар нэгэн Үндсэн хууль зөрчсөн асуудал алга. Харин ҮХЦ-ийн гишүүн Дээд шүүхийн шүүгч, прокурор, орлогч прокурорыг томилох нь бол Үндсэн

хууль зөрчсөн байна гэж үзсэн. Энэ дээр бол та бүхэн дүгнэлтээс нь харах байх.

Энэ ч гэсэн өөрөө энэ хууль батлагдаж байх үед Энхбаяр гишүүн энийг гол санаачилж байсан хүн. Бас багагүй парламент дээр маргаан өрнүүлж байсныг санаж байна. Яагаад гэхээр тухайн жишээлбэл ҮХЦ-ийн гишүүн дээр Их Хурал 3-ыг санал болгож байгаа бол Их Хурал нь өөр дээрээ сонсголоо хийх ёстой. Ерөнхийлөгч 3-ыг санал болгох юм бол, Дээд шүүх нь 3-ыг санал болговол тус бүр дээрээ журам гаргаад сонсгол томилгооны сонсгол хийж болно. Тэгэхгүй бол Ерөнхийлөгчийн санал болгож байгаа хүнийг парламент дээр авч ирж сонсгол хийх нь бол энэ бүрэн эрхэд нь халдсан ч байдаг юм уу ийм зүйлүүд байна гэдэг зүйлийг бол ярьж байсныг та мэдэж байгаа. Гэхдээ ийм шийдвэр гарсан. Гарах мэдээжийн хэрэг тайлбарыг нь бол та бүхэн бол харж байгаа байх. Мэдээж энэ Монгол Улсын төрийн байгууллагуудын шүүх байгууллагуудын хараат бус байх, хэн нэгэн байгууллага, хэн нэгэн хувь хүнээс хамааралгүй байх, томилогдохынхоо өмнө ямар нэгэн амлалт авдаггүй байх гээд олон зүйл заалтуудыг зааж шийдвэр гаргасан байна.

Тэгээд Их Хурлын гишүүд ХЗБХ, Их Хурал энэ Цэцийн дүгнэлтийг хүлээж авах эсэх нь бол бас та бүхний асуудал. Би бол мэдээж Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийн хувьд бол Их Хурлын баталсан энэ Хяналт шалгалтын хуулийг хамгаалах тал дээр бол өөрсдийн тайлбарыг өгч ажилласан. Энийг гаргасан үндсэн шалтгаан бол та мэдэж байгаа шүү дээ. Өмнө нь энэ ҮХЦ-ийн гишүүнийг томилохдоо тэр битгий хэл бүүр бараг хуулийн мэргэжилгүй тухайн салбартаа ажиллаж байгаагүй хүмүүсийг томилж байсан. Энэ агуулгаараа энэ.../минут дуусав/

**Б.Энхбаяр:** Мөнх-Оргил сайд асуултаа асууя.

**Ц.Мөнх-Оргил:** Сайн байцаана уу? Энэ их нюанстай асуудал ярьж байна шүү гишүүдээ. Хэдүүлээ тал талаас нь сэтгэлийн болон аливаа хувиралгүйгээр ярих асуудал болчихоод байгаа юм байна. 1 дүгээрт энэ процессын асуудал байна. ҮХЦ Улсын Их Хуралд хангалттай хугацаа өгсөн байна шүү дээ. Жил болсон байна шүү дээ хурлаа хийгээгүй. Тэгээд жил болж байхад Улсын Их Хурлын төлөөлөгч ямар нэгэн шалтгаанаар хуралд оролцож чадаагүй бол Цэц хурлаа хийж л таарна шүү дээ. 26-нд хурал болох гэж байна 25-нд ир гэж хэлж байгааг бид нар буруутгах бас арга байхгүй шүү дээ. Тэр чинь бас л яг бидэнтэй адилхан төрийн эрх мэдэл барьж байгаа нэг том салбар байхгүй юу. Ажлаа хийж байна. Бид нар ч гэсэн Улсын Их Хурал ч гэсэн маргааши хурал зарлаж байна, тэр байтугай үдээс хойш хурал зарлаж байна гээд л өчнөөн төрийн албан хаагчдыг л ажлаас нь хөндийрүүлээд л, дуудаад л, авчраад л энэ тархи толгойгүй загнаад л ажлаа хийгээд л явдаг шүү дээ. Тэгэхлээр энэ дээр бол процессын талаас буруутгах юм алга гэж би харж байна 1 дүгээрт.

2 дугаарт энэ байна шүү дээ гишүүдээ энэ төрийн эрх барьж байгаа том институтүүдийн хоорондын асуудал байхгүй юу. Тийм учраас энд шууд ингээд л буруутгаад л танилцуулах эрхэд халдлаа гэж ярихаасаа илүү энэ балансыг яг олж уу үгүй юу гэдгийг л хармаар байгаа юм. Жишээ нь би бол энэ дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүд, хуульч мэргэжилтэй туслахуудтайгаа хамтарч сууж байгаад, Тамгын газартайгаа хамтарч сууж байгаад илүү сайн дүгнэлт хийж үзэх ёстой юм байна гэж харж байгаа юм. Энэ чинь бүх танилцуулах энэ нээлттэй сонсгол хийхийг буруутгаагүй байна шүү дээ. Дотор нь ялгачихсан байгаа байхгүй юу. ШЕЗ-ийг бол болж байна гэж байна, үндэслэлийг нь тайлбарлачихсан байна. Яагаад вэ ойлгомжтой байхгүй юу. Тэд нар чинь ШЕЗ-ийн гишүүн болж амжаагүй байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ шүүхийн хараат бус байдалд халдаагүй гэдэг нь ойлгомжтой.

Болчихсоных нь дараа бид нар авчраад нээлттэй сонсгол хийгээд байх юм бол тэр хараат бус байдалд нь халдчихаж байна. Энийг зөвшөөрчхөж байна.

АТГ-ын даргыг бас хэлж байна. Болно хийж болно. Яагаад вэ, яагаад гэвэл томилох эрх нь та нарт байж байна гээд. ШЕЗ юу энэ цэцийн гишүүн дээр нюанстай хандаж байна. Яагаад вэ, яагаад вэ сая Ганболд гишүүн хэллээ шүү дээ. Анх энэ хуулийг баталж байхад бид нар ярьж байсан шүү дээ. Ерөнхийлөгч тэндээ нээлттэй сонсголоо хийчих. Тэгэхгүй бол тэнд сонгож, сонгож, шалгаруулж, шалгаруулж авчирсан хүнийг энэ дахиад Улсын Их Хурал шүүгээд байх чинь утгагүй юм байна. Хэдүүлээ Ерөнхийлөгчийн нэр дэвшүүлснийг эсвэл дэмжье эсвэл дэмжихгүй гэдгээ хэлээд л явуулчихъя. Томильё, томилохгүй гэдгээ хэлээд л явуулья гээд. Тэгэхээр энэ чиглэлээр бид нар хуульдаа засвар хийгээд явах юм бол би тэр институтүүдийн хоорондын балансыг барих талдаа илүү зөв зохистой гаргалгаа байна гэж харж байна.

Юун дээр шүүгч дээр бол бас нюанстай юм энэ Цэц хэлсэн байна шүү дээ. Шүүгчийг чинь Улсын Их Хурал танилцуулснаар байхгүй юу, Улсын Их Хурал өөрөө томилох гэж байгаа биш байхгүй юу. Шийдвэр гаргах гэж байгаа биш, танилцуулах гэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр дахиад л нөгөө Үндсэн хуулийн асуудал гарч ирээд байгаа юм л даа. Яг зөвшилцөнө, томилно гэж хоёрын хоорондох зөвшилцөнө гэдэг чинь яг юу гэсэн үг юм бэ гэдэг нөгөө эрх зүйн агуулгынх нь л маргаан гараад байна шүү дээ, тийм ээ. Танилцана гэж яг юу гэж байгаа юм, зөвшилцөнө гэж яг юу гэж байгаа юм бэ? Томилох бол ойлгомжтой болчихлоо. Бид нар нээлттэй сонсголоо хийгээд томилчихож болж байгаа байхгүй юу.

Тэгэхээр Тамгын газрынхан энэ дээр тэр ялгаануудыг нь гаргаж байна уу, үгүй юу? Ер нь бол байна шүү дээ энэ яг

том зургаар нь харах юм бол энэ яг энэ шүүгчийн хараат бус байдал, шүүхийн бие даасан байдал гэж яг эрх зүйн хувьд яг юу гэсэн утгатай юм бэ гэдэг нэг маргаан. Төрийн эрх барих дээд байгууллага, Улсын Их Хурал төрийн эрх барих дээд байгууллага гэдэг Үндсэн хуулийн том заалтын агуулга нь бас яг юу юм гэдэг энэ ерөөсөө л эрх зүйн агуулгын тийм маргаан л болж байна л даа тэнд. Би бол энэ харин ч Цэц.../минут дуусав/

**Б.Энхбаяр:** Мөнх-Оргил гишүүн. Нэмж асууя. Мөнх-Оргил гишүүн нэмэлт асуулт асууя. Мөнх-Оргил гишүүний микрофоныг өгөөрэй.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Тэгэхлээр энэ дээр бол хэдүүлээ жоохон нухацтай хандмаар юм байна. Улсын Их Хурлын Тамгын газрын манай хуульч экспертүүд, зөвлөхүүд, шинжээчид энэ дээр ямар нэгэн дүгнэлт гаргасан юм байна уу? Яагаад гэвэл Ганболд гишүүний явуулсан нөгөө манай Тамгын газрынхан бэлдэж өгсөн байх л даа. Тэр тайлбар дээр бол яг энэ нөгөө эрх зүйн агуулгыг нь задлахгүйгээр энэ ямар ач холбогдолтой юм бэ гэдгийг л тайлбарлаад байгаа байхгүй юу. Ач холбогдолтойг нь бол бид нар ойлгож байна. Гэхдээ ач холбогдолтой ч гэсэн тэр нь энэ Үндсэн хуулийнхаа заалттай нийцэж байна уу, үгүй юү гэдэг чинь бас тусдаа асуудал байгаа байхгүй юу. Тэгэхээр энэ талаар нь манай Тамгын газрынхан тайлбар өгвөл сонсчихмоор байх юм. Тэгээд би бол дараа нь саналаа хэлэхээр нь тодорхой санал хэлье гэж бодож байна.

**Б.Энхбаяр:** Ганболд гишүүн хариулья.

**Г.Ганболд:** Ер нь бол яах вэ бид нар ерөөсөө энэ Улсын Их Хурлын хяналт шалгалтын хуулийг гаргахдаа хууль санаачлагчид яг энэ заалтуудыг оруулсан бид нарын хамгийн гол үндэслэл бол ерөөсөө энэ өмнөх явж байсан томилгоонууд дээр л гол нь, өмнөх явж байсан томилгоонууд дээр томоохон

алдаанууд гарч байсан. Тийм учраас ямар ч гэсэн энэ сонсгол бол тухайн хүний нэр дэвшиж байгаа хүний хувьд тухайн ажилд мэргэжил мэргэжлийн хувьд тэнцэж байна уу үгүй юү, ёс зүйн хувьд тэнцэж байна уу үгүй юү, энэ чиглэлээрээ яг ажиллаж байсан уу үгүй юү, энийг бол нийгэмд хамгийн гол нь таниулах ёстой гэдэг ийм л логикоор бид нар батлаад явсан шүү дээ. Зүгээр яг Мөнх-Оргил гишүүний хэлснээр бол би ойлгож байна. Эхлээд бид нар бол яг эхлээд тухайн иргэний гаргасан маргаантай холбогдуулбал 2 заалт байсан юм. Тэрэн дээр нь бол бид Их Хурлын Тамгын газрынхантай бол нэлээн сайн ажилласан. Сүүлд нэхэмжлэлээ нэмэгдүүлснээс хойш асуудлаар бол яг үнэндээ бид нар энэ нэг бүрчлэн яг Үндсэн хуулийн заалт бүрээр нь бас яг Цэцийн гаргасан дүгнэлт бол үнэхээр бас нарийн гаргасан байна гэдгийг би тантай санал нэг байгаа. Бас зарим нэг гаргасан дүгнэлтүүдийг нь би ч гэсэн хэдийгээр Их Хурлын итгэмжилсэн төлөөлөгч ч гэсэн бас хүлээн зөвшөөрөхөөс аргагүй ийм нарийн Үндсэн хуулийн заалтууд гаргаж шийдвэрлэсэн байна лээ. Тэгээд энэ дээр надад ямар нэгэн байдлаар таны бүх заалтууд дээр нь хуулийнхантай нэг бүрчлэн Үндсэн хуулийн заалтууд дээр яг ажиллаад явсан зүйл бол бас тэр тал дээр дутуу ажилласан байж магадгүй гэж ингэж бодож байна.

**Б.Энхбаяр:** Сүхбаатар гишүүн асуултаа асууя.

**Ж.Сүхбаатар:** Би яах вэ Их Хурлын хяналт шалгалтын хуулийн ажлын хэсгийн ахлагчаар ажиллаж байгаад энэ хуулийг батлуулсан хүн л дээ. Тэгээд яах вэ асуултаас илүүтэй бас тайлбарлах гэдэг юм уу протоколд бас орох ёстой л доо. Улсын Их Хурал танилцана, зөвшилцөнө гэдгийг бол нөгөө хараат бус байдал алдагдуулах талаас нь Цэц хүлээж авсан байна л даа. Үндэслэлдээ бол жишээлбэл Монгол Улсын Ерөнхийлөгч, Дээд шүүх, холбогдох эрх бүхий этгээд нэгэнт сонгон

шалгаруулалт хийж, нэр дэвшүүлж, санал болгож байхад дээрх зохицуулалтаар тухайн бүрэн эрхэд нь хөндлөнгөөс нөлөөлөх шууд бусаар халдах боломжийг олгосон байна гэдэг агуулгаар гэж. Энэ тэгээд ийм л дээ.

Энэ Улсын Их Хурал гэдэг чинь ард түмний төлөөлөгчдийн дээд байгууллага, тэгээд Ерөнхийлөгч, Дээд шүүх ингээд танилцах, зөвшилцөх юм энэ урьд нь юу, юу болоод байсан юм бэ гэхээр Улсын Их Хуралд байгаа гишүүд олонх ч гэдэг юм уу, Ерөнхийлөгч, Дээд шүүх эд нар урьдын олон жилийн практик нь юу болсон юм бэ гэхээр зэрэг явцуу хүрээнд, олон түмэнд мэдэгдэхгүйгээр, гишүүд хүртэл гүйцэд танилцах боломж олгохгүйгээр энэ танилцах, зөвшилцөх ажиллагааг явуулж, тэгснээрээ Дээд шүүхийн гэдэг юм уу, шүүхийн үйл ажиллагаа, Цэцийн үйл ажиллагааны энэ олон удаагийн шүүмжлэл гараад байгаагийн их үндэс болоод байна гэдэг шүүмжлэл явсаар байгаад энийгээ яаж балансжуулъя гэж үзсэн юм гэхээр зэрэг энэ танилцах, зөвшилцөх сонсголыг Их Хурлын гишүүд танилцуулахаасаа илүүтэй олон түмэн иргэдэд ард түмэндээ танилцуулдаг байя. Тэгэхээр тэр процедурын боломж нь энэ сонсголын явцад иргэд мэдэх эрхээ эдэлье, мэдээллээ авъя, байр сууриа хэлье. Тэгээд тэр хүнтэй холбоотой муу, сайн юмнуудыг нь бүгдийг нь дурдъя, ярья.

Тэгэхдээ энэ хараат бус байдлыг зөрчиж байгаа гэж хэрвээ үзэх юм бол тухайн бас санал болгож байгаа этгээд ч гэсэн тухайн хүнийг өөрөө санал болгож байгаа учраас тэр халаасны хүн байх боломжтой болчихоод байгаа байхгүй юу. Тэгэхээр бүгдийг нь ингээд хуваачих, тэр хүн халаасны хүн болгож бас тэр гаргахгүйгээр нэгэнт танилцах, зөвшилцөл, сонсголоор орох учраас бүх юмаа уудлуулах учраас хариуцлагатай хандаг. Өөрөө хэдийгээр санал болгож байгаа томилох гэж байгаа эрх бүхий этгээд ч гэсэн. Их Хурлын танилцах, зөвшилцөх гэдэг бол зүгээр нэг Их Хурлаар танилцуулсан болоод зөвшилцсөн болоод

өнгөрөөгөөд явуулъя гэсэн хэрэг биш. Танилцсан ч бай, зөвшилцсөн ч бай энэ бол олон түмэнтэйгээ хуваалцаж байгаа эрх мэдлийг хэрэгжүүлъя, наад зах нь мэдээлэл авъя. Тэгээд энэ дээр нь санал бодлоо хэлэх боломжийг нь иргэдэд олгоё гэдэг санаа байгаа.

Түүнээс гишүүд Ерөнхийлөгч, Дээд шүүхийн хооронд урьд нь ингээд зөвшилцсөн болоод, танилцсан болоод шийдээд байсан нь бол олон асуудал дагуулсан юм л гэдгийг засах гэж энэ сонсголыг бол хийж байгаа. Ингэснээрээ бол бүх талууд тэнцвэржиж байгаа юм. Дураараа дур зоргоороо аль нэг тал, эсвэл 2 тал, 2 институт хоорондоо ойлголцсон гэдэг юм уу, муухайгаар хэлбэл хуйвалдаад шууд шийдчихэж байгаа юм биш үү. Бүүр жинхэнэ энэ улсын эзэд болсон ард түмэн, иргэд, сонирхогч талууд нь энэ мэдээллийг аваад санал бодлоо хэлээд тэгээд тэр танилцаж байгаа, зөвшилцөж байгаа талууд ч гэсэн энэ иргэдийнх нь санаа бодол дээр үндэслээд байр сууриа хэлдэг. Томилох гэж байгаа этгээд ч гэсэн тухайн хүнийхээ талаар Улсын Их Хурлын гишүүд болоод олон түмний санаа бодлыг харгалзаж байгаад тэгээд яг бас томилох эсэхээ шийддэг байх ч гэдэг юм уу ийм байгаа юм. Тэгэхээр Их Хурлын гол юм бол энэ шүү дээ. Ер нь энэ сонсголын чинь гол агуулга бол иргэдийн олон түмэнд ингээд Их Хурлын гишүүд бол хэн юм бэ гэхээр зэрэг ард түмний төлөөлөгч. Тэгээд Үндсэн хуульд зааснаар иргэд энэ засгийн бүх эрх ард түмний мэдэлд байна, тэгээд төлөөлөгчдөөрөө дамжуулж энэ эрхээ эдэлнэ гээд заачихаар энэ томилгооны үйл явц эд нар хэдэн институтийн хооронд ингээд явчхаж байгаа биш, эцсийн эцэст иргэд шударга шүүхээр шийдэлгүй эх эрхтэй, Үндсэн хуулийн эрхтэй.

Тэгээд шүүх эрх мэдэлд үнэлэлт дүгнэлт өгөх боломжтой байх ёстой. Тухайлбал Японы Үндсэн хуульд байж байгаа шүү дээ. Дээд шүүхийн шүүгчдийг нь бол 10 жил байх, үнэлэлт дүгнэлт сонгуулийн үеэр өгөх боломжтой гээд



зүгээр механизмын хувьд бол маргаантай байдаг ч гэсэн цаад философийнхоо хувьд бол энэ бол бие даасан байдал алдагдуулна гэж байгаагаасаа илүүтэй манай Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчдөөр орсноор олон түмний засаглах цаад эрхийг нь өөрөө ингэж балансжуулах замаар, түүрүүн Мөнх-Оргил гишүүн баланс гээд байгаа чинь эцсийн дүндээ энэ бол бүх талуудын балансыг л олуулах зорилготой шүү дээ.

**Б.Энхбаяр:** Бямбацогт гишүүн больсон байна. Итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Ганбат гишүүнээр тасаллаа. Мөнх-Оргил гишүүн үгээ хэлье.

**Ц.Мөнх-Оргил:** Баярлалаа. Энэ Цэц чинь бол ингэж л хэлчхээд байна шүү дээ. Нээлттэй сонсгол хийх нь жишээ нь Ерөнхийлөгч ҮХЦ-ийн гишүүнээр нэр дэвшүүлэх эрхэд хөндөж байна уу үгүй юү гэдэг асуултад бид нар хариулт өгөх гээд байна шүү дээ. Цэц бол хөндөж байна гээд хэлчхээд байна 1 дүгээрт.

2 дугаарт ийм нэр дэвшүүлчхээд байхад ийм сонсгол хийх нь энэ тухайн юу ҮХЦ-ийн бие даасан хараат бус байх баталгааг алдагдуулж байна уу үгүй юү гэдэг л 2 дахь асуулт байна шүү дээ тийм ээ. Тэрэнд бол бид бол үгүй гэж хэлж байгаа. Дээд, Цэц бол энэ баталгааг нь алдагдуулаад байна гэж хэлээд байна. Тэгэхээр би бол зүгээр нэг ийм л саналтай байх юм Их Хурлын даргаа. Энэ асуудлаа өнөөдөр хэдүүлээ ярьчхаад эцсийн шийдвэр зөрчсөн байна, зөрчөөгүй байна гэдэг юмыг дараагийн хурлаар ярья. Нэг жоохон судлах юмнууд байна, хувилбарууд байна. Жишээ нь 2 хувилбар байна шүү дээ. Ерөнхийлөгч нэр дэвшүүлчхээд байхад бид нар энд сонсгол хийх юм уу эсвэл Ерөнхийлөгч заавал тэнчээгээ сонсгол хийж байх юм уу. Тэнд Ерөнхийлөгч сонсголоо хийчхээд Их Хурал томилох томилохгүйгээ шийддэг нэг хувилбар байна. Эсвэл Ерөнхийлөгч

сонсгол хийсэн хийгээгүй нэгэнт томилох эрх нь бид нарт байгаа учраас томилох уу үгүй юү гэдэг шийдвэрээ гаргахаасаа өмнө Их Хурал сонсгол хийнэ гэж үзэх юм бол 2 дахь хувилбар нь тэр байгаа байхгүй юу одоогийнхоороо явах нэг хувилбар байна. Өөрөөр хэлбэл Цэцийн дүгнэлтийг хүлээж аваад, хуулиа засаад явах нэг хувилбар байна.

Эсвэл томилох эрхтэй учраас бид нар ийм, ийм ач холбогдолтой учраас нээлттэй сонсгол хийж байна гэж. Мэдээж нээлттэй сонсгол хийх бол маш ач холбогдолтой чухал. Энэ бол том дэвшил. Энийг бол бид бүгд хүлээн зөвшөөрч байгаа. Тэгэхдээ энэ нээлттэй сонсголоо бусад институттэйгээ ойлголцож, балансыг нь хадгалж, нэг талаас ард иргэдийн болон Улсын Их Хурлын гишүүдийн мэдэх ойлгох, таних эрхийг нь нээж өгөөд нөгөө талаас энэ Үндсэн хуулиар олгогдсон онцгой бүрэн эрхүүдэд нь халдахгүйгээр зохион байгуулах арга зам байна уу үгүй юү гэдгийг нэг судалж үзмээр байна.

2 дахь нэг асуулт бол энэ хамгийн чухал асуудал энэ Ерөнхийлөгч нөгөө Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гээд байгаа шүү дээ. Энэ ерөөсөө гол асуудал болчхоод байгаа юу байхгүй юу шүүгчийг, Дээд шүүхийн шүүгч, одоо бид нар жишээ нь Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшиж байгаа хүний асуудлыг ярих гэж байна шүү дээ. Танилцуулна гэдэг чинь яг юу гэж байгаа юм бэ? Намтар түүхийг нь уншаад бид нар орхичхож байна уу? Одоо болтол явж байгаа практикийг бид нар нэг бүрэн харж үзмээр байгаа байхгүй юу. Би бол танилцуулна гэдэг дээр үзчихээд Ерөнхийлөгчид энэ хүн чинь болох юм байна болохгүй юм байна гэдэг зөвлөмж өгөх ёстой гэж би бол хувьдаа ойлгоод байгаа байхгүй юу. Агуулга нь тийм байх ёстой. Тэрнээс зүгээр намтар түүхийг нь танилцуулчхаад Ерөнхийлөгчөө бид нар танилцчихлаа шүү, Байнгын хороогоороо энэ хүний намтартай танилцчихлаа шүү гэж хэлээд, Ерөнхийлөгч нь буцаах бол

тэр Үндсэн хуулийн танилцуулснаар гэдэг үгийн эрх зүйн агуулга нь тэнд байхгүй болчихоод байгаа байхгүй юу.

Тэгэхээр бүүр Ерөнхийлөгч, Цэц, Дээд шүүхтэйгээ ойлголцож энэ Улсын Их Хурлынхаа дэгт өөрчлөлт оруулаад тэр хүний талаар бүүр зөвлөмж гаргадаг баймаар байгаа юм. Өөрөөр хэлбэл бид нар Ерөнхийлөгчийн томилох эрхэд халдаагүй байна. Танилцуулах эрхээ хэрэгжүүлэхдээ энэ хүний талаар ард түмний төлөөлөл болсон Улсын Их Хурал юу гэж бодож байгаа юм бэ гэдэг юмаа хэлмээр байгаа байхгүй юу. Тэгээд үндэслэлтэй хэлмээр байгаа юм. Жишээ нь өмнө бид нар 3 ч Дээд шүүхийн шүүгчийн томилгооны саналыг танилцлаа шүү дээ. ШЕЗ-өөс оруулаад л ярьдаг, учир дутагдалтай байна гээд ярьж, ярьж ярьж ярьчихаад тэгээд Ерөнхийлөгчид энэ хүнтэй энэ хүнийг танилцчихлаа гээд л юм явуулчихаж байгаа байхгүй юу. Нөгөө гишүүдийн ярьсан үндэслэл ерөөсөө юу ч байхгүй. Тэгэхээр энэ хамгийн гол асуудал энэ байна. Энийгээ нэг мөр цэгцлээд, тэгээд энэ Цэцийн энэ дүгнэлт дээр тайлбараа өгвөл яасан юм бэ? Хариугаа өгвөл яасан юм бэ?

Өөрөөр хэлбэл миний дэгийн горимын санал бол хэлэлцчихье. Яг шийдвэр гаргах нөгөө нэг томъёолол байгаа шүү дээ тийм ээ, үндэслэл гаргаж ирнэ шүү дээ бид нар. Үндэслэлээ бид нар бэлдэх хэрэгтэй байна. Цаасан дээр бүүр бэлдээд, бүх гишүүдэд танилцуулчихаад, тэгээд Байнгын хороон дарга танилцуулаад ийм үндэслэлээр энийг нь хүлээж авлаа, ийм үндэслэлээр энийг нь хүлээж авахгүй. Энийг нь хүлээж авбал хуулиа ингэж өөрчилье гэдэг. Нэг ёсондоо нэг арай нэг хамтын ажиллагааны гэх юм уу, Цэцтэй хамтарч ажиллаж байгаа ажиллагаагаа арай жоохон нэг талаас уян хатан ажил хэрэгч болгох л хувилбар л даа. Тэрнээс биш шууд хүлээж авлаа, авахгүй гээд орхичихмооргүй байгаа юм. Үндэслэлийг нь гаргаж өгчхөөд яримаар байгаа юм. Ийм л санал байна дарга.

**Б.Энхбаяр:** Энэ нөгөө хуулийн хугацаатай байгаад байгаа юм. Цэцийн дүгнэлтийг 5 хоногийн дотор ХЗБХ хэлэлцэх ёстой 1-д. 2-т нөгөө Мөнх-Оргил сайдын ярьж байгаа асуудал бол Улсын Их Хурал хэрвээ Цэцийн шийдвэрийг хүлээж авъя гэвэл ХЗБХ холбогдох нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргадаг. Хэрвээ хүлээж авбал Мөнх-Оргил сайдын хэлж байгаа энэ нөгөө агуулгаар Хууль зүйн байнгын хороо хуулийн холбогдох хуулийн төсөл санаачлах үед энэ асуудлыг бас боловсруулах үедээ бас ярих боломж үүсэх байх. Одоо бол хүлээж авах эсэх асуудлыг Улсын Их Хурал шийдээгүй байгаа. Хүлээж авч ч болно, хүлээж авахгүй ч байж болно. Энд шийдвэр нь гараагүй байгаа учраас хувилбарууд бас ярих саяын хувилбар дээр тодорхой саналуудыг бол мэдээж ярьж болох юу байгаад байна. Мөнхцэцэг гишүүн үгээ хэлье.

**Ц.Мөнхцэцэг:** Тэгэхээр энэ Цэцийн дунд суудлын хуралдаанаас гаргасан энэ шийдвэр бол яг Үндсэн хууль зөрчсөн буюу Ерөнхийлөгчийн болон бусад институтийн бүрэн эрхэд халдсан байна гэдэгтэй бол санал нийлэхгүй байгаа юм. Бид нар гол анхаарах зүйл нь энэ тодорхой албан тушаалтнуудад нэр дэвшсэн хүмүүсийн томилгоо нээлттэй сонсгол бол шийдвэр гаргах тийм процесс биш. Тухайн нэр дэвшигч нар хэн болох, ямар тухайн шүүх хуулийн практикт ажилласан, тэгээд олон нийтийн олон нийтдээ мэдээлэл өгөх, тухайн албанд томилогдвол энэ ажлыг хаших практикийн болоод боловсролын хувьд ямар таарах вэ гэдгийг л нээлттэй болгож байгаа хэлэлцүүлэг. Гэтэл энэ дунд суудлын хуралдааны шийдвэрүүд бол нээлттэй сонсголыг шийдвэр гаргах процесс гэж үзсэн шинжтэй байгаад байгаа байхгүй юу. Энэ нээлттэй сонсгол бол бид нар нэлээн хэдэн удаа хийчихлээ. ХЭҮК-ын гишүүд, ШЕЗ-ийн гишүүд гээд. Ер нь бол энэ чинь олон нийтэд мэдээлэл өгөх гэж байгаа л үйл ажиллагаа болохоос биш тэр ҮХЦ-ийн юм байна уу, эсвэл Ерөнхийлөгчийн бүрэн эрхэд халдсан

шинжтэй ийм үйлдэл биш. Энэ Үндсэн хуулийн тодорхой заалтуудыг бол зөрчсөн байх үндэслэлгүй байгаад байгаа юм.

Ер нь бол энэ чинь угаасаа олон улсын практик байгаа учраас энэ Хяналт шалгалтын тухай хуулиар нэр бүхий гишүүд бүгд өргөн барьсан ийм механизм байгаа. Тэгээд энэ нээлттэй сонсгол явагдлаа. Тодорхой хугацаанд нэр дэвшигч хүмүүс маань материалуудаа танилцуулж, олон нийтийн болон хараат биш шинжээчдийн дүгнэлт, тухайн нэр дэвшигчийн танилцуулга дээр ажиллана. Тэгээд урьд өмнөх бүх тэр хардлагуудыг хэний хүн томилогдож байгаа юм Дээд шүүх, ҮХЦ-д. Энэ аль бүлэг фракц юм бэ гэдэг энэ хардлагуудыг бол алга болгож байгаа шүү дээ. Ерөөсөө л олон нийтэд мэдээлэл гаргах буюу энэ ардчиллын шууд ардчиллын чинь хамгийн чухал шинжийг хангасан ийм том процесс байгаа. Тийм учраас бид нар энэ Цэцгийн дунд суудлын хурлын дүгнэлтийг бол Улсын Их Хурал хүлээж авах ёсгүй. Энэ хэн нэгний бүрэн эрхэд халдсан биш ерөөсөө л олон улсын жишигээр нэр бүхий томоохон төрийн албан тушаалын томилгоог бол ил тод болгох энэ процесс болохоос биш бид нар бол хэн нэгний бүрэн эрхэд халдаагүй, Үндсэн хууль зөрчөөгүй гэж үзэх үндэстэй байгаад байна.

Тэгээд ер нь бол энэ ард түмний дунд хардлага байдаг. Хэнийг ямар хүнийг томилсон, ямар албан тушаалтан хэн оччихов? Энэ болгоныг чинь ил тод болгож, хардлагагүйгээр, тэгээд тухайн бүрэлдэж байгаа тэр ҮХЦ байна уу, Улсын Дээд Шүүх байна уу энэ Дээд шүүхийн чинь өөрийнх нь олон түмнээр хүлээн зөвшөөрөгдөх буюу энэ төрийн том институтүүдийн чинь нэр хүндэд энэ нээлттэй сонсгол маань илүү нөлөөлнө. Тэгэхээр ард түмэн бол мэдэх нь байна шүү дээ. ҮХЦ-ийн энэ гишүүн бол ийм туршилагатай, ийм олон улсын судалгаа юутай хүн байна гэдгээр. Тийм учраас бид нар нөгөө шүүхэд итгэх итгэл, шүүх шударга хараат бус байх ажилд энэ нээлттэй сонсгол маань үнэхээр дэвшил

оруулж байгаа. Тэгэхээр бид нар Монгол Улсын Их Хурал энэ ардчиллын зарчмаасаа, энэ нээлттэй ил тод байх зарчмаасаа ухрах ёсгүй. Тийм учраас Улсын Их Хурал энэ дүгнэлтийг хүлээж авахгүйгээр яах ёстой. Ер нь бол ард түмэнд мэдэх эрх, хардах эрх байгаа. Тэрийг бид нар хүндэлж энэ шийдвэрийг гаргасан.

**Б.Энхбаяр:** Сүхбаатар гишүүн үг хэлье.

**Ж.Сүхбаатар:** Яах вэ ер нь зүгээр энд нэг Цэцийн зүгээр анхаарал татсан нэг юм байгаа. Тухайн албан тушаалтны онцлогтой холбогдуулан анх болон дахин томилогдохтой холбоотой зохицуулалтыг нарийвчлан хуульчлах шаардлагатай тэмдэглэх нь зүйтэй гэж байна. Зүгээр энийг бол би бол Улсын Их Хурал яах вэ анхаарч ч болно. Ерөнхий прокурор, Цэцийн гишүүд бол дахин томилогдох боломжтойгоор ингээд явж байгаа. Ер нь бид нарын бодлого бол Цэцийн гишүүдийг уг нь урт хугацаагаар нэг удаа л томилъё гэдэг юм явж байгаа. Тэгээд дахин томилогдоно гэдэг асуудал бол үүсгэж байгаа. Дээд шүүхийн гишүүд бол яах вэ ингээд нэг томилогдчихвол ингээд тэтгэвэрт гартлаа явахаар шахуу ингээд байж байгаа. Тэгэхээр энэ дахин томилогдох дээр бол тэр үнэлэлт дүгнэлт гаргаад, яг яачихгүй асуудал дээр бол Улсын Их Хурал руу жоохон тодруулга бол хийх нь бол зөв байж болно.

Яагаад гэвэл өмнөх үйл ажиллагааныхаа талаар ч гишүүдтэй холбоотой бусад маргаануудыг шийдвэрлэсэн талаасаа дараагийн удаа үнэхээр дахин томилогдох тэр боломжийг цаашидаа би томилохгүй л юм бол тэр тохиолдолд бол Цэцийг энэ дүгнэлтийн энэ хэсгийг бол яах вэ анхаарч болно. Яагаад гэвэл тухайн улсуудад хийсэн ажилтай нь холбогдуулаад тухайн томилгооны үеэр гишүүдээс янз бүрийн хэлбэрээр гэдэг юм уу бусад этгээдээс энэ нөлөөлөх бололцоо бас байж үүсэж болохыг үгүйсгэхгүй. Тэрийг бол Их

Хурлын шалгалтын хууль дээр анхаарах нь бол зөв байх.

Гэхдээ бүхэлдээ нөгөө зөвшилцөх танилцах энэ механизмыг Үндсэн хууль зөрчсөн гэж ингэж үзэхийг бол хүлээж авах боломжгүй байгаа юм. Энэ чинь бүүр том утгаараа попорч байгаа биш шүү дээ. Олон түмэндээ танилцуулж байгаа юм. Олон түмэнтэйгээ зөвшилцөж байгаа юм. Зарим үед Их Хурлын гишүүд дангаараа асуудлыг өөрөө мэдэж ард түмний төлөөлөгчийн хувьд кноп дарахаас гадна, зарим нэг онцгой асуудлаар бол иргэдтэйгээ хуваалцаж, өөрийнх нь эрхийг нь өгөөд явуулсан нөгөө иргэдтэйгээ хуваалцаж эрх мэдлээ хийх тэр боломжийг чинь үгүйсгэж болохгүй. Их Хурал ер нь тэр хандлага руу их явж байгаа шүү дээ. Юмаа зөвлөлддөг, санал авдаг. Энэ хуулийн төслийг яах вэ? Иргэдээ та нар саналаа хэл. Тэгээд тэр саналаа. Би түүний чинь дагуу тэгвэл ингэж хандъя ч гэдэг юм уу. Энэ агуулга руу улам бүүр Улсын Их Хурал орж байгаа байхгүй юу. Тэрнээс чи төлөөлөгч одоо ингээд чи тэнд очоод л бүгдийг нь шийдээд бай гэдэг биш. Ер нь бол бас бид нар энэ хандлага руу бас ороод байгаа шүү дээ. Заримыг нь бид кнопдож байгаа ч гэсэн илүү их хугацаа зарж байгаад иргэдтэйгээ илүү их зөвшилцөж, танилцуулж, ойлголцох тусам асуудал зөв гарна гэж.

Тэгэхээр энэ танилцан, зөвшилцөнө гэдэг нь Их Хурлын гишүүд танилцан зөвшилцөнө гэж утгаараа илүү биш олон түмэнд танилцуулах, олон түмэнтэй бас зөвшилцөж байгаа процесс шүү. Ялангуяа манай улсын хувьд бол маш хэцүү байгаа асуудал бол шударга ёсны асуудал гээд ярьж байна шүү дээ. Тэгэхээр тэр асуудлынхаа хүрээнд бол энэ танилцах зөвшилцөх процедур чинь бол өмнө нь явж ирж байгаа, би түрүүн хэлсэн шүү дээ гажуудлуудыг засаад, хардлага сэрдлэг байна, харин ч хараат болчихлоо гэж яриад байгаа шүү дээ. Энэ нэр дэвшүүлж байгаа этгээдээсээ, томилж байгаа этгээдээсээ хараат

байна гээд дундуур нь Их Хурлын гишүүдийг эрхийг бас хязгаарлаж байгаа байхгүй юу. Улсын Их Хурлын гишүүдийн эрхийг хязгаарлаад томилж байгаа санал болгож байгаа талуудын эрхийг хязгаарлаад хэн нь ч давуу эрхтэй байхгүйгээр олон түмэн ингээд хараа хяналтдаа байлгаж байгаад оролцоотой байлгаж байгаа, иргэдийн оролцоотой байлгаж байгаа чинь өөрөө энэ балансжуулна гэдэг механизмынх нь энэ нэр дэвшигчийн томилгооны сонсголын чинь онцлог нь эндээ байхгүй юу. Бүх тал руу балансжиж байгаа байхгүй юу даа адилхан. Тэгэхгүй бол хэдэн албан тушаалтан байгууллагын хооронд яриа хөөрөө явахаар хэн ч томилогдож байгааг мэддэггүй. Тэр талд ч шийдвэр гаргаж байна гэж яриад байдаг.

Тэгэхээр энэ байдлаас зайлсхийх гээд дэвшилтэд механизм оруулсан. Зүгээр тэрэн дотор тэр ганц нэг тэр мэдээж хэрэг хууль болсон хойно хэрэглэж байгаа үзэхэд бол бас эрсдэлүүд байгааг хараад тэрийг сайжруулах ёстой болохоос биш түүнийх нь механизмынх нь эрэг боолтыг нь авч хаяад, ингээд энэ болохгүй юм байна гэж хэлэх юм бол энэ ухралт болчих гээд байгаа байхгүй юу гол агуулга. Тэгэхдээ Цэцийн тэр дүгнэлтийн тэр анхаармаар юмыг бол ер нь Их Хурлын шалгалтын хуулийн заалтын заримыг нь ер нь бас жоохон сайжруулъя гээд байгаа шүү дээ. Энэ Их Хурал ажлаа өгөхөөсөө өмнө ядаж энэ хуулийг хэрэглэж үзсэний хувьд зарим дүгнэлтээ хийгээд, нэг зарим нэг хэсэг дээр нь өөрчлөлт хийчихмээр байгаа юм. Тэгэхдээ тэр үедээ бол яах вэ энэ дахин томилогдохтой харилцаан дээр Ерөнхий прокурор, Цэцийн гишүүдийн тухайд бол дахин томилогдох үе дээр нь бол ингэж болохгүй шүү гэдэг байдлаар заримыг нь хумьж өгөөд, тэгээд тэрийгээ явах ёстой болохоос биш ер нь Их Хурлын танилцан зөвшилцөнө гэдэг чинь бол та нар бол нэг их сонсгол хийж болохгүйгээр зүгээр кноподчих. Дотроо бодож байгаад ингээд кноподчих гэдэг нь бол энэ чинь яав ч зөв эрүүл биш байна шүү дээ. Энүүгээр чинь

олон жил явсан шүү дээ. Тэгээд яваад яваад болоогүй л байхгүй юу.

Тэгээд дэлхийн улс орнуудад бид нар харж л байгаа шүү дээ. Дээд шүүхийн шүүгч, тэр ҮХЦ шүүхэд нь явж байгаа улсад танилцуулагдаж л байдаг шүү дээ мэдээлэл нь. Нэг өдрийн дотор манайх чинь бол яачихсан бэ гэхээр 1, 2 өдрийн дотор л оруулаад тэгээд хурдан кнонд гээд л ингэдэг л ажил шүү дээ. Тэгээд энийг л зассан юм. Тэгэхээр энийгээ бол наанатай цаанатай авч үзээд, энэ бол бас Монгол юу Монгол Улсын парламентын хяналт шалгалтын механизмын хамгийн амин чухал хэсэг учраас энэ шийдвэрийг ингээд болчимгүй гаргах юм бол энэ үүд хаалгыг хаах юм бол дараа том маргаан дээдэнэ шүү дээ. ҮХЦ-ийн гаргасан шийдвэртэй холбогдуулж хэдэн жил маргаан болж байгаад тэгээд засагдах л юм болно шүү дээ дараа нь. Тэгэхээр хаана хаанаа л ойлгох л ийм л асуудал.

**Б.Энхбаяр:** Раднаасэд гишүүн үгээ хэлье.

**Ш.Раднаасэд:** Энэ томилгооны сонсголын зүйл дээр би зарим талаар Мөнх-Оргил гишүүнтэй санал нэг байна. Наадах чинь илт үг зүйн хувьд ч гэсэн, утга агуулгын хувьд ч гэсэн Улсын Их Хуралд танилцуулснаар энэ томилно, энэ томилно гээд ингээд биччихсэн юмыг аваачаад дунд нь зөвшилцөнө гэдэг үг оруулчхаж байгаа юм. Танилцана гэсэн ийм юм оруулчихсан байгаа байхгүй юу. Энэ зөвшилцөнө гэдэг чинь ярина гэсэн үг шүү дээ. Тийм үгүй, ав авахгүй гэдэг юм. Тэгээд энэ чинь яах аргагүй зөрчлийн юм гарч ирээд байгаа байхгүй юу. Тэгээд энэ дээр Их Хурал өөрөө өөрийгөө томилдог албан тушаалтнууд руу сонсгол хийх эрх нээлттэй. Бусад субъектийн томилдог зүйлүүд дээр бид нар хуулийн өөрчлөлтийг нь энэ дотор нь хийгээд өгчихсөн нь дээр байх. Одоо энийг хүлээж аваад. Тэгэхгүй бол энэ чинь зөв буруу, үнэн худлаа гээд тэртээ тэргүй энэ нэг Цэц дээр очоод дахиад яалт ч үгүй ингээд Үндсэн хууль дээр биччихсэнээс өөрөөр бид нар бичээд

хууль баталчхаад байгаа байхгүй юу. Энэ хяналт шалгалтын хууль гэдгээр. Цэц дээр очоод энэ хүчингүй болно өөрөө. Бид нар хүлээж авахгүй гэж жил дараад ч гэсэн. Бүүр нуухыг нь авах гээд бүүр бүхэлдээ энэ хэсгийг чинь бүүр байхгүй болгочихно шүү дээ. Бүх албан тушаалтнууд чинь энэ дотор чинь ганцхан Цэцийн гишүүний асуудал биш байна шүү дээ. Хүний эрхийн Комисс байна, ТАЗ байна, Монголбанкны, Ерөнхийлөгч байна. Ингээд бүх албан тушаалтнуудын чинь асуудал эвгүй байдалд оччихоод байгаа байхгүй юу.

Тэгээд миний санал бол энэ Мөнх-Оргил гишүүний хэлдгээр энийг хүлээж аваад харин янзлаад, Их Хурал өөртөө хамаарахаа бол явуулдгаараа явуулаад, энэ Цэцийн дүгнэлтэд дурдсан тэр бусад субъектийн томилгоотой холбоотой зүйлүүд дээр нь бол яг оролцох оролцох түвшиндээ л оролцохгүй бол хил хязгаарыг нь давж оролцох гээд дэмий байх л гэж харагдаж байна. Энэ яалт ч үгүй энэ Үндсэн хууль дээр бичсэнээс өөрөөр бичээд л гаргачихсан юм байна.

**Б.Энхбаяр:** Ганбат гишүүн үг хэлье.

**Д.Ганбат:** Уул нь одоо ганц энэ Улсын Их Хурлыг бас ард түмэнтэйгээ хамт байгаагийн нэг илэрхийлэл болсон энэ зүйл л дээ. Сонсгол гэдэг бол тухайн албан тушаалтан энэ зүйлд бол нөлөөлөөд байгаа гэж бодохгүй байгаа. Нөлөөлдөг ч үгүй шүү дээ. Тэрний нэг тод илэрхийлэл нь Худалдаа хөгжлийн банкны талаар явсан сонсголыг хийсэн түр хороо. Хөгжлийн банкны талаар, Хөгжлийн банкны талаар. Түүн дээр бол түүн дээр сонсголд оролцсон хүмүүс маань шүүх шийдвэр гаргасан шүү дээ. Яг Соёлын төв өргөөнд бараг нэг үзмэр маягтай бараг 20, 30 хоног хуралдаад ингээд шийдвэр гарахдаа тэр хүмүүс ямар ч ял зэм хүлээгээгүй шахуу. 40 тэрбумыг ч юм уу, 4 тэрбумыг идсэн нөхдүүд 40 саяар торгуулж бариад л ингээд л гараад явчихсан. Тэгэхээр энийг бол Улсын Их

Хурал хамгаалдаггүй хаацайлдаггүй юм байна. Энэ шүүхэд нөлөөлдөггүй юм байна, энэ шүүх чинь өөрөө болохоо байчихсан юм байна гэдэг ийм ойлголт ард түмний дунд үлдсэн байх л даа.

Энэ хэвлэл мэдээллээр явж байгаа, ярьж байгаа энэ бүх юмыг хараад байхад. Бид нар энэ сонсголыг нөлөөлж байна гэж ийм ойлголттой байлгах гээд байх юм. Зүгээр л энэ байгаа хүмүүс томилгоо хийж байгаа нь, санал болгож байгаа энэ хүмүүс чинь ийм л байдалтай байна шүү дээ гэдгийг л ард түмэн харж байгаа шүү дээ. Олон түмэн мэдэх эрхийнхээ хүрээнд. Би сая Мөнхцэцэг гишүүн, Сүхбаатар гишүүн 2-ын тэр илэрхийлж байгаа санал бодолтой нэг байна. Үгүй ээ энэ заваан хутгасан юмаа нөгөө Цэц нь өөрөө л дуусгаг л даа. Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгчийг оролцуулаагүй юм уу, оролцуулах сонирхолгүй юм уу, өөрсдөө оролцоогүй юм уу ийм байдалтайгаар ингээд гаргаж байна.

Нөгөө талаар бол нөгөө иргэний гаргасан тэр хэмжээнд л энэ асуудлыг Цэц шийдэх ёстой шүү дээ. Тэгтэл бүүр өргөжүүлээд ингээд шийдсэн юм шиг харагдаад байх юм. Тэр хуулийнх нь заалт юм дотор байгаа байсаар байтал. Нөгөө талаар бол ҮХЦ өөрөө өөрийнхөө талаар эрх мэдлийг өргөжүүлэх, өөрөө аль болохоор тэр хар бараан юман дотор цаанаа нуугдаж хийх энэ юмны талаар ингэж дүгнэлт гаргаж болох юм уу? Энэ чинь ёс зүйд нийцэх юм уу. ҮХЦ-д хэн ч нөлөөлдөггүй. Уул нь олон түмэн мэдсэний дараа бол энэ хүмүүс чинь өөрсдөө тэр ёс суртахууныхаа юмыг яагаад уучлалт гуйгаад энэ Монголын Үндсэн хуулийг байхгүй болгосныхоо төлөө бүгдээрээ л огцорч байх ёстой. Тэр байтугай өнөөдөр ҮХЦ, Улсын Дээд шүүх 2-ыг бид нар бараг нэгтгэсэн ч болохоор шүү дээ. Ямар ч тийм ойлгомжгүй байгууллага үүсчээд байна.

ҮХЦ-ийг манадаг биш Үндсэн хуулийг Цэц нь өөрөө өөрчилдөг, дуртай

үедээ тэрийг Үндсэн хуулийг хэдэн 100 жил засагддаггүй ийм явсан ийм улс орнууд байдаг шүү дээ. Дуртай үедээ л өөрчилдөг шүү дээ. Сонгууль болгоны өмнө л давхар дээлтэй, дээлгүй болгож өгөөд. Тэгээд нөгөө санал болгож байгаа 3 газар байгаа Улсын Их Хурал нь, Улсын дээд шүүх нь, Монгол Улсын Ерөнхийлөгч нь. Энэ хүмүүсээс санал болгож байгаа хүмүүс нь ямаршуухан яаж ажилладаг юм, яадаг юм ийдэг юм гэдэг нь л бүгд харагдаж байгаа шүү дээ. Энэ өнөөдрийн эрх мэдэл бүгдээрээ л ард түмнээс эх үүсвэртэй шүү дээ. Тэгээд ард түмэн ямар хүнийг томилж, ямар байдлаар ажиллуулж байгаагаа мэдэх эрхээ л алдах нь байна. Улам л харанхуй, улам л тэр мэдээлэл байхгүй, мэдээллийг хэдхэн хүн өмчилдөг, хэн дуртай хүнтэйгээ тавьдаг, нөгөөдөх нь ядаж ёс зүйн хариуцлага хүлээдэг баймаар байна шүү дээ. Тэр лүү ингээд орж байна улс орон бага багаар явж байна. Иргэд маань өнөөдөр шал өөр болчихлоо шүү дээ. Энэ дэлхий нийтийн жишигээ дагаад.

Гэтэл бид нар өнөөдөр ийм юм яриад байж болохгүй. Тэр Үндсэн хуулийнх нь цэц нь тэгээд өөрөө өөрийнхөө юмыг тэгээд өөрөө завааруулаад л дуусгана биз. Тэгээд Монголын ард түмэн ҮХЦ-д ямар хүмүүс ажилладаг, ямар хүмүүс санал болгож тэнд очоод байж байгааг хараад л байж байг. Ганц зөв зүйтэй хийсэн юмаа Улсын Их Хурал ХЗБХ баллаж болохгүй байх гэсэн ийм бодолтой байна. Тийм. Ер нь хүлээж аваад хэрэггүй дээ.

**Б.Энхбаяр:** Би гишүүнийхээ хувьд бас байр сууриа илэрхийлье. Миний хувьд бол ҮХЦ-ийн 2023 оны 05 тоот дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэсэн байр суурьтай байгаа. Монгол Улс бол ардчилсан улс. Бид ардчилсан Үндсэн хууль 30 гаруй жилийн өмнө баталсан гэдгээрээ бахархдаг. Бид мөн төлөөллийн ардчилалтай, ард түмэн нь төрөө шууд сонгодог, чөлөөтэй сонгодог, дарангуйлагч дэглэмтэй улс биш ээ гэдгээрээ бид бахархаж түүнийгээ улам

хамгаалахыг эрмэлздэг. Сая Ганбат гишүүн хэлж байна. Үндсэн хуульд бол заасанчлан засгийн бүх эрх мэдээлэл ард түмний гарт байгаа. Ард түмэн өөрсдийн төлөөлөгчдөөрөө дамжуулж, төрийг удирдах хэрэгт оролцдог. Тэд нь төлөөлөгчид нь бол бид байгаа.

Улсын Их Хурал бол ард түмний төлөөллийн дээд байгууллага. Тэр утгаараа ард түмнээсээ эрхээ авсан, ард түмэндээ нээлттэй, мөн ард түмэндээ тайлагнаж хариуцлагаа үүрдэг ийм засаглал бол ардчилсан засаг. Ард түмнийг бид үгээрээ тулгаж, хүчээр дарангуйлдаг дэглэм биш. Үүний эсрэг явж байгаа. Бид ард түмнийхээ улам их итгэлийг олж явахын гол үндэс нь бол нээлттэй байдал, тунгалаг байдал, ойлгомжтой байдал. Занданиатар даргатай парламент энэ чиглэлд бол маш бодитой өмнө нь явж ирсэн ийм парламент ёсны жишигт бас хувьсгалт шинжтэй ийм алхмуудыг хийж явж байгааг та бүхэн мэдэж байгаа.

Тэр нь бол ХЭҮК-оос эхлээд, ШЕЗ, сахилгын хороо, Улсын Их Хурлын удирдлагууд Улсын дээд шүүхийн шүүгчдийг хүртэл нээлттэй сонсголоор оруулж, ард түмэнд нээлттэй байдлаар шүүсийг нь шахаж, зам мөрийг нь шүүж, бодлого юмтай нь танилцаж шийддэг болж эхэлсэн. Та бүхэн санаж байгаа бол анх парламентын гишүүн 20 онд орж ирээд яг энэ танхимд Улсын Дээд шүүхийн шүүгчээр Голомт банканд ажиллаж байсан хүнийг бид нарыг Байнгын хороо хурал хийх гэж байхад ширээн дээр намтрыг нь тавьж байсан. Тэгээд бид танилцахгүй гэж эсэргүүцэж байсныг та бүхэн санаж байгаа. Нэг банкны шүүгчийг Монгол Улсын шүүхийн засаглалын оройд тавихгүй. Ийм гар хөл болсон ийм хүмүүсийг тавихгүй гэдэг асуудлаар эсэргүүцэл илэрхийлж байсан. Ерөөсөө хаалттай байдлаар хэдхэн дарга нарын хүрээнд өнгөрсөн 30 жилд хууль сахиулах байгууллагын энэ олон томилгоонуудыг хийж ирсэн. Энэ нь шударга ёсыг тэд өмчилдөг, нөгөө хонгил

үүсдэг, өрсөлдөгчөө намнадаг ийм дэглэмийг бий болгосон. Бид үүнийг нураах юм сан, нураахын төлөө энэ танхимаас хүчтэй бодлого явуулсан. Үүний үр дүнд Сүхбаатар гишүүн ахлаад хяналт Улсын Их Хурлын хяналт шалгалтын хууль батлагдсан.

Үүгээр Монгол Улсын Их Хурлаас томилогддог 40 гаруй албан тушаалтан нээлттэй сонсголоор ордог болсон. Энийг Үндсэн хууль зөрчиж байгаа гэдэг бол Монгол Улсын парламентыг ард түмнээс нь хаалттай болгох гэж байна гэсэн үг. Нээлттэй байх нь Үндсэн хууль зөрчсөн гэдэг шийдвэр гаргадаг Үндсэн хууль бид батлаагүй. Манай Үндсэн хууль бол ардчилсан Үндсэн хууль. Ард түмэндээ улам бүүр нээлттэй байх тухай ийм хариуцлагатай байх тухай ийм Үндсэн хууль. Гэтэл энэ томилгоонуудыг нь эсрэгээрээ буцаагаад хаалттай болгох нь зүйтэй, нээлттэй байгаа нь Үндсэн хууль зөрчиж байна гэдэг ийм Цэцийн дүгнэлтийг бол ойлгохгүй байгаа. Саяын ярьж байгаа Цэцийн дүгнэлтэд байгаа зарим асуудлуудыг бол хүлээж авах боломжтой асуудлууд бас байна.

Тухайлбал тэр өмнө нь нэгэнт нээлттэй шалгуураар ороод, томилогдчихсон хүн дахиж томилогдох гэж байгаа бол түүнийг заавал дахиад хэлэлцээд байх шаардлагагүй гэдэгтэй миний хувьд бол санал нэг байна. 2 дугаарт яг Улсын дээд шүүхийн шүүгч болон ҮХЦ-ийн гишүүн нэр дэвшигчтэй холбоотой асуудал дээр парламентын гишүүд тухайн хүний шийдвэрлэж байсан хэрэг маргаантай холбоотой асуудлаар байр сууриа илэрхийлэх ийм зүйлийг бол бас хуулиар хязгаарлалт тавьж бол болох байх. Тодорхой хэргийг чи тэгж шийдсэн байна лээ, чи ингэж шийдсэн байна лээ гээд нөгөө шийдэж байсан хэрэг рүү орох бол тэр бол хараат бус байдал руу нь нэвтэрч байгаа ийм үйлдэл бол болно гэж үзэж байгаа юм. Энэ асуудлуудыг нь Хяналт шалгалтын хуулиараа боловсронгуй болгоод аваад явчих

боломж бол Улсын Их Хуралд бол би байгаа байх гэж бодож байгаа.

Тэрнээс бус ерөөсөө сонсгол хийдэг нь эдгээр албан тушаалтны хувьд буруу, Үндсэн хууль зөрчиж байна гэж байгаа энэ чиг хандлага бол өөрөө би бол буруу байна гэж үзэж байгаа. Тийм учраас энэ Занданшатар даргатай парламентаас баталсан бодлого нээлттэй байх, ардчилсан байх энэ бодлого дээрээ бол үнэнч байхыгаа илэрхийлж, энэ Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй байгаа гэсэн ийм байр сууриа илэрхийлье.

Гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Санал хураалт 1. Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 75 хувийн саналаар Цэцийн санал дэмжигдсэнгүй, хүлээн зөвшөөрөхгүй гэж үзлээ.

Санал хураалт 2. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар хүлээж авахгүй гэж байна.

Санал хураалт 3. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1 дэх заалтад “Үндсэн хуулийн цэцийн гишүүн, ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт 100 хувийн саналаар хүлээн зөвшөөрөхгүй гэж үзлээ.

Санал хураалт 4. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар хүлээн зөвшөөрөхгүй гэж үзлээ.

Санал хураалт 5. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. Энэ саналаар саналыг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзлээ.



Санал хураалт 6. Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “... нэр дэвшигчийн сонсгол хийж ...” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 90.9 хувийн саналаар саналыг хүлээн зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 7. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Үндсэн хуулийн цэц, түүний гишүүн үүргээ гүйцэтгэхдээ гагцхүү Үндсэн хуульд захирагдах бөгөөд аливаа байгууллага, албан тушаалтан, бусад хүнээс хараат бус байна.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар хүлээн зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 8. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Үндсэн хуулийн

цэцийн гишүүний хараат бус байдал Үндсэн хууль, бусад хуулиар тогтоосон баталгаагаар хангагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 100 хувийн саналаар саналыг хүлээн зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 9. Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 102 дугаар зүйлийн 102.1 дэх хэсэгт “... энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонсгол зохион байгуулна. ... нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ... тухайн тайлан, ... Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран тавдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуулийн цэц есөн гишүүнээс бүрдэнэ. Тэдгээрийн гурвыг Улсын Их Хурал, гурвыг Ерөнхийлөгч, гурвыг Улсын дээд шүүхийн санал болгосноор Улсын Их Хурал зургаан жилийн хугацаагаар томилно.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 12, одоо 10 дахь санал. 100 хувийн саналаар саналыг зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 10. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад “... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол.” гэж заасны “... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ...” гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин есдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Шүүгч хараат бус байж, гагцхүү хуульд захирагдана.” гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 90,9 хувийн саналаар саналыг хүлээн зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 11. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсгийн "Шүүхийн ерөнхий зөвлөлөөс Улсын дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар ... Ерөнхийлөгч томилно." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 90,9 хувийн саналаар саналыг хүлээн зөвшөөрсөнгүй.

Санал хураалт 12. Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2 дахь заалтад "... эсхүл Улсын Их Хурал танилцах, зөвшилцөх, томилохоор хуульд заасан албан тушаалтны хувьд танилцах, зөвшилцөх, томилгооны сонсгол явуулахаар Улсын Их Хурлын есөөс доошгүй гишүүн хүсэлт гаргасан бол." гэж заасны "... танилцах, зөвшилцөх, ... танилцах, зөвшилцөх, ..." гэсэн нь Монгол Улсын Үндсэн хуулийн Тавин зургаадугаар зүйлийн 2 дахь хэсгийн "Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг Улсын Их Хуралтай зөвшилцөн Ерөнхийлөгч зургаан жилийн хугацаагаар томилно." гэж заасныг зөрчсөн байна гэснийг хүлээн зөвшөөрөх нь зүйтэй гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 90,9 хувийн саналаар саналыг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзлээ.

Санал, ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцэж дууслаа. Монгол Улсын ҮХЦ-ийн 2023 оны 5 дугаар дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг улсын чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их

Хурлын гишүүн Ганболд танилцуулна. Мөнхцэцэг гишүүн танилцуулъя чуулганы нэгдсэн хуралдаанд.

10.52 цаг

### **Хоёр. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй танилцах**

Дараагийн асуудалдаа оръё. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчтэй хийх нэр дэвшигчийн танилцуулга хэлэлцэнэ. ШЕЗ Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулж, гишүүд ШЕЗ-ийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно. Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Намсрайн Батзоригийг ШЕЗ-ийн дарга Онончимэг танилцуулъя. 4 номерын микрофоныг өгье.

**Р.Онончимэг:** Улсын Их Хурлын гишүүд ээ,

Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэгт ШЕЗ-өөс Улсын Дээд шүүхийн шүүгчдийг Улсын Их Хуралд танилцуулснаар Ерөнхийлөгч томилно гэж, Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэгт Ерөнхий зөвлөл Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулснаар томилуулах саналыг Ерөнхийлөгчид хүргүүлнэ гэж, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хуулийн 104 дүгээр зүйлийн 104.2 дахь хэсэгт нэр дэвшигчийг ШЕЗ-ийн дарга ХЗБХ-ны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна гэж тус тус заасан. Үүний дагуу Улсын дээд шүүхийн шүүгчийн Иргэний хэргийн танхимын шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Намсрайн Батзоригийн Батзоригийг ХЗБХ-нд танилцуулж байна. Нэг товч намтар.../үг тасрав/

**Б.Энхбаяр:** Дууссан уу?

**Р.Онончимэг:** Нэг товч намтар. Намсрайн Батзориг 1975 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал суманд төрсөн, 48 настай, эрэгтэй, ам бүл 5. 1982-1990 онд Хэнтий аймгийн Дэлгэрхаан сумын бүрэн бус дунд боловсролын сургууль, 1990-ээс 92 онд Хэнтий аймгийн 1 дүгээр 10 жилийн бүрэн дунд сургууль, 1993-аас 94 онд Дотоодын цэргийн 805 дугаар ангид хороонд байлдагч, 1995-1999 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургууль эрх зүйч бакалавр, 2016-2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль хууль зүйн ухааны магистрын зэргийг тус тус хамгаалсан. Эрх зүйч мэргэжилтэй. Тэрээр 1992-оос 93 онд Хэнтий аймгийн Цэнхэрмандал сумын ЕБС-д биеийн тамирын багш, 1999-өөс 2005 онд Багануур дүүргийн шүүхийн тамгын газрын хэсгийн төлөөлөгч, 2005-аас 2007 онд Улсын Дээд шүүхэд Танхимын тэргүүний туслах, 2007-гоос 2012 онд Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, 2012-оос 2013 онд Орхон аймгийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, 2013-аас 2015 онд Нийслэлийн Шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр ажиллаж байна. Нэр дэвшигч Батзориг нь 2023 оны 10 сарын 2-ны өдрийн байдлаар төрийн албанд 26 жил, шүүгчээр 16 жил 4 сар, үүнээс давж заалдах шатын шүүхийн шүүгчээр 11 жил 7 сар ажиллаж байна.

2.Хуульд заасан шалгуур хангасан байдал. Нэр дэвшигч Батзориг нь Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 3 хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлд заасан хяналтын шатны шүүхийн шүүгчид тавих болзол шаардлагыг дараах байдлаар хангаж байна. 1.Хууль зүйн дээд боловсролтой байх. Нэр дэвшигч Батзориг нь 1995-аас 1999 онд Шихихутаг Хууль зүйн дээд сургууль, эрх зүйч бакалавр, 2016-аас 2018 онд МУИС-ийн Хууль зүйн сургууль хууль зүйн ухааны магистрын зэрэг хамгаалсан. 2.35 нас хүрсэн Монгол Улсын иргэн байх. Нэр дэвшигч Батзориг нь 1975 оны 5

сарын 9 төрсний өдөр төрсөн 48 настай, Монгол Улсын иргэн. 3.Эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй байх. Нэр дэвшигч Батзориг нь гэмт хэрэг зөрчилд холбогдон шалгагдаж байгаагүй тухай ЦЕГ-ын холбогдох албаны 2023 оны 5 сарын 2-ны өдрийн 13Б/14 03 дугаар албан бичиг мөн эрүүгийн хариуцлага хүлээж байгаагүй тухай Etmongolia.mn цахим мэдээллийн сангийн 2023 оны 4 сарын 24-ний өдрийн лавлагаагаар тус тус тодорхойлогдоно. Шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй байх. Батзориг нь шүүгчид нэр дэвших үед яллагдагчаар татагдаагүй тухай Монгол УЕПГ-ын 2023 оны 6 сарын 7-ны өдрийн 4/49 59 дүгээр албан бичгээр лавлагаа ирүүлсэн. 5.Шүүгчээр ажиллахад харшлах өвчин сэтгэцийн эмгэггүй болохыг тогтоосон эрх бүхий байгууллагын мэргэжсэн эмчилгээ магадалгаатай байх. Нэр дэвшигч Батзоригийг эрүүл мэнд сэтгэцийн талаар холбогдох эрүүл мэндийн байгууллагын 2023 оны 3 сарын 30-ны өдрийн дүгнэлтээр эрүүл тэнцэнэ гэж дүгнэсэн.

6.Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөлтэй байх. Нэр дэвшигч Батзориг нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх хүчин төгөлдөр зөвшөөрөлтэй. Монголын Хуульчдын холбооноос 2014 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн 18 16 дугаартай гэрчилгээг шинэчлэн олгосон. Нэр дэвшигчийн хуульчийн мэргэж гэрчилгээ хүчинтэй тухай Монголын Хуульчдын Холбооны 2023 оны 5 сарын 3-ны өдрийн 2/441 дүгээр албан бичгээр лавлагаа ирүүлсэн. 7.Шүүгчээр ажиллах мэдлэг, чадвар, ёс зүйтэй байх. Нэр дэвшигч Батзориг нь хууль зүйн мэдлэг чадварын шалгалтад 53,03 оноо, мэргэжил, ёс зүй, зан төлөвийн шалгалтад 26,53 оноо авч хяналтын шатын шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн. 8.Мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан байх. Нэр дэвшигч Батзориг

нь шүүгчээр нийт 16 жил 4 сар, 2027 оны 2007 оноос 2012 онд Орхон аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч, 2013-аас 2010, 12-оос 13 онд Орхон аймгийн давж заалдах шатын шүүхийн шүүгч, 2013-аас 2015 онд Нийслэлийн шүүх, Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын 10 дугаар шүүхийн шүүгч, 2015 оноос Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр тус тус ажилласан туршилагатай.

9. Сүүлийн 6 жил улс төрийн болон улс төрийн намын удирдах албанд тушаал эрхэлж байгаагүй байх. Нэр дэвшигч Батзориг нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн 2015 оны 6 сарын 30-ны өдрийн 111 дүгээр зарлигаар Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн шүүгчээр албан тушаалд томилогдон өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа тул сүүлийн 6 жилийн хугацаанд аливаа улс төрийн болон улс төрийн намын удирдах албан тушаал эрхэлж байгаагүй гэж үзнэ. 10. Улсын Дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүйн доошгүй нь шүүгч байх шалгуур. Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.6 дахь хэсэгт Улсын дээд шүүхийн нийт шүүгчийн 2/3-оос доошгүй нь энэ хуулийн 31.4.1-д заасан шүүгч байна гэж заасан. Одоогоор Улсын дээд шүүхэд 23 шүүгч ажиллаж байгаагаас 16 шүүгч, 7 нь прокурор, өмгөөлөл магадлан итгэмжлэгдсэн хууль зүйн их дээд сургуулийн багш буюу бусад хуульчдын төлөөлөлд ажиллаж байна. Нэр дэвшигч Батзориг нь шүүгчээр 10-аас доошгүй жил ажилласан тул энэ шаардлагыг хангаж байна.

Сонгон шалгаруулалтад тэнцсэн байдал. Нэр дэвшигч Батзориг нь Монгол Улсын Шүүхийн тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.9 дэх хэсэг, ШЕЗ-ийн 2022 оны 10 дугаар сарын 18-ны өдрийн 300 дугаар тогтоолд заасны дагуу хүчинтэй байгаа 79,56 үнэлгээгээр 1 дүгээрт эрэмбэлэгдсэнийг ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 14-ний өдрийн 173 дугаар тогтоолоор баталсан.

4. ШЕЗ-ийн санал, ШЕЗ-ийн 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 179 дүгээр тогтоолоор шийдвэрлэсний дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн 51 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсгийг баримтлан Монгол Улсын дээд шүүхийн шүүгчийн сул орон тооны сонгон шалгаруулалтад 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигч Намсрайн Батзоригийг Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчээр томилуулах саналыг Монгол Улсын Их Хуралд танилцуулж байна. Танилцуулга дууслаа.

**Б.Энхбаяр:** Онончимэг даргад баярлалаа. ШЕЗ-ийн дарга болон нэр дэвшигчээс асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрээ өгнө үү. Ажлын хэсгийн микрофон юу цаг үргэлжилж яваад байна, техникийнхэн энийгээ хаагаарай. ШЕЗ-ийн дарга болон нэр дэвшигчээс асуух асуулттай Улсын Их Хурлын гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Энх-Амгалан гишүүн асуултаа асууя.

**Б.Энх-Амгалан:** Та бүгдийн энэ өдрийн амгаланг айлтгая. ШЕЗ-ийн даргаас асуулт асууя. Нэр дэвшигчдтэй бол ингээд ажилласан байдал, төгссөн сургууль, эрдмийн цол зэрэг, салбартаа мэргэшсэн байдлыг нь харахад бол энэ Улсын дээд шүүхийн шүүгчид бол нэр дэвшиж байгаа хүн нь бол мэргэжил арга зүйн хувьд шаардлага хангаж байгаа ийм хүн орж ирж байгаа юм байна гэж би ингэж ойлгож байна. Ажлын амжилт хүсье танд.

ШЕЗ-өөс би юу асуух гээд байна вэ гэхээр зэрэг сүүлийн үед хууль хяналтын байгууллагууд олон нийтийн радио, телевизээр, нийгмийн сүлжээгээр сошиал сүлжээнд ингээд гэмт хэрэг ярьдаг боллоо. Гарч ирж байгаа, шалгаж байгаа, мөрдөж байгаа гэмт хэргээ ингээд сайхан тэгж байна, ингэж байна гээд яриад. Тэрнийхээ араас дахиад ингээд зохиол бичээд гүтгэлэг явуулдаг боллоо. Уул нь

тэр мөрдөн байцаагчаас өөр хүн тэрийг мэдэх ёсгүй юм л даа. Тэгээд тэр гарч ирээд ерөөсөө ингээд тэгсэн гэнэ, ингэсэн гэнэ гээд ингээд зохиол бичээд байдаг. Тэгээд энэ нийгэмд олон хүний бухимдлыг төрүүлээд, тэгээд 1 хулгайчаар баахан дуудуулж, дуудуулж байгаад тэгээд сүүлд нь хамж аваачаад боогоод шүүх рүү өгөөд, тэгээд шүүх дээр ганцхан зүйл ярьдаг. Одоо шүүх л яаж шийдэхийг харъя.

Энэ шүүхэд нөлөөлж байгаа нөлөөлөл мөн үү? Яг энэ дээр шүүх хараат бус байж байх ийм нөхцөл байдал байна уу? Ийм учраас энэ дээр цаашдаа ер нь ШЕЗ, Шүүхийн сахилгын хороо энэ тэр нь ямар арга хэмжээ авах юм бэ? Ингээд энэ маань ингээд цаашаа яваад байх юм уу. Тэгээд явж, явж байгаад сүүлдээ шүүх дээр асуудал нь буучих гээд байдаг. Ингээд мөрдөөд өгсөн шүү дээ. Тэгсэн чинь шүүгч нар л ингэж шийдлээ. Шүүх л шударга бус байна гэдэг ийм юм руугаа орчих гээд байдаг. Тэгэхээр энэ шүүхийн нэр хүндийг хамгаалах, шүүхийн хараат бус, бие даасан байдлыг хангахад ямар арга хэмжээ цаашдаа авах гэж байна гэдэг асуудлыг асууя.

**Б.Энхбаяр:** ШЕЗ-ийн дарга Онончимэг хариулъя. 4 номерын микрофон.

**Р.Онончимэг:** Энх-Амгалан гишүүний асуултад хариулъя. Ер нь шүүгчийн хараат бус байдал, бие даасан байдлын талаарх Үндсэн хуулийн зохицуулалтыг бол сая 2021 онд орж ирсэн батлагдсан Шүүхийн тухай хуулиар илүү тодорхой процессыг бол нэлээн сайн зохицуулж өгсөн. Энэ хүрээнд бол шүүгчид нөлөөллийн мэдүүлэг өөрөө хүсэлт гаргавал бичдэг. ШЕЗ олон нийтийн сошиалын, олон нийтийн зүгээс нөлөөлж байгаа мөн төрийн өндөр албан тушаалтнууд нөлөөлж байгаа эд нар гэсэн асуудлууд дээр тухай бүр хуралдаж шаардлагатай тохиолдолд хэлэлцэн шийдвэрлэх ийм зохицуулалтууд орж ирсэн байгаа.

Өнгөрсөн 1 жил 8 сарын хугацаанд бол бид энэ чиглэлээр бас нэлээн олон ажлууд хийгдсэн. Төрийн өндөр албан тушаалтай холбоотой 4 хүнтэй холбоотой хуралдааныг хийж, холбогдох эрх байгууллагууд бас уламжлах, мэдэгдэл гарах энэ ажлуудыг хийж зохион байгуулж явж байна. Ер нь бол яах вэ шүүхийн хараат бус байдал бол энэний ар талд эдийн засгийн баталгаа, шүүхийн төсвийн асуудал байдаг. Тэгэхээр магадгүй энэ дараагийн хуралдаанаар шүүхийн төсвийн асуудал орж ирнэ. ХЗБХ 6 сард шүүхийн бас хянасан. Тэгэхээр энэ талаас нь бас та хэдийг дэмжиж ажиллаасай гэж хүсэж байна. Баярлалаа.

**Б.Энхбаяр:** Ганбат гишүүн асуултаа асууя.

**Д.Ганбат:** Өнөөдөр энэ шүүх шүүхтэй холбоотой байгууллагуудын нэр хүнд бол энэ олон нийтийн дунд үнэхээр тааруу байгаа гэж би ойлгож байна. Энэ хэвлэл мэдээллийн байгууллагуудын явж байгаа байдлыг харахад шүүхэд итгэхэд иргэдийн итгэл бол маш тааруу болсон. Энэ юутай юутай холбоотой байна гэж ШЕЗ үзэж байна вэ? Нэр дэвшигч ч гэсэн юу гэж бодож байна вэ?

Нөгөө талаар энэ Улсын Дээд шүүхийн шүүгчид хэр олон хүн нэр дэвшсэн юм бэ, энэ орж ирж байгаа хүн маань тэр шалгаруулалтад ямар байр эзэлсэн юм гэсэн ийм асуулт байна.

Энэ шүүгч нарын эдийн засгийн нөхцөл байдлыг арваад жилийн өмнө би сайжруулж өгсөн юм. Энэ шүүгч нарын цалинг би бараг 2 мянган доллар дээр аваачсан. Тэгээд эдийн засгийн хувьд боломжийн болгож өглөө гэж бодоод нэг хэсэг бол маш сайн байсан. Сүүлийн хэдэн жил бол 1 мянган доллар орчим хавьцаа байгаа болов уу. Тэгтэл үнэхээр аягүй тааруу ажиллаж байна. Би энэ Хөгжлийн банкны хэргийг ярих гээд байгаа юм. Ард түмний мөнгө төгрөгийг хулгайгаар

завичихсан энэ шүүгч маань Иргэний хэргийн танхимд л очих байх л даа Дээд шүүхийн. Тэгээд тэр хүмүүс маань 40 тэрбумыг, 4 тэрбумыг ингээд аваад завшаад ингэчихсэн мөртөө 40 саяар торгуулаад гарч байна. Тэр шүүгчийг миний ойлгосноор бол Хэнтий аймгаас татаж авчраад тавьсан уу, зориуд тэгж тавиад ийм шийдвэрийг гаргалаа гээд хэвлэл мэдээллээр явж байна лээ л дээ. Тэр хэр үнэний ортой юм бэ? Ийм байж болдог юм уу яадаг юм бол? Энийг эсэргүүцэж нөгөө прокурор нь эсэргүүцэл бичсэн үү үгүй юу?

Гэтэл бид нар багш нарынхаа цалинг нэмж чадахгүй байна шүү дээ. Багш нарын цалинг мянган доллар болгох ёстой. Хэрэв шүүх сайн ажиллаад, тэр хүмүүсийн өмч хөрөнгийг хураагаад, ийм зүйлийг хийсэн бол улсын өмч хөрөнгө буцаад татвар төлөгчдийн мөнгө зориулагдах зүйл дээр зориулсан бол өнөөдөр багш нар маань мянган долларын цалинтай л байх байлаа шүү дээ. Тэгээд энэ Ховд, Увс, Хэнтийнхэн, ер нь нэг аймгийн хэчнээн хүмүүс хэр хэмжээгээр энэ шүүхэд байдаг юм бэ? Та 2 чинь хоёулаа Хэнтийнх байна уу үгүй юу? Эсвэл өөр аймаг юм уу, бас буруу зөрүү хэлбэл уучлаарай. Тийм. Энэ тоо байна уу? Улсын дээд шүүх дээр ямар хувьтай байдаг юм бэ? Нөгөө хонгил үүсгэж байна, хонгил бий боллоо энэ тэр гээд бид нар ингээд яриад байдаг л даа. Энэ нөлөөлдөг юм уу, нөлөөлдөггүй юм уу, ямар байдаг юм бэ? Үнэхээр Дээд шүүхийн хараат бус байдал маш тааруу байна л даа.

Тэгээд энэ улс орныг уруудаж доройтуулахад, энэ ард түмний аж амьдралыг ийм хүнд болгоход бол та бүхний хариуцлагагүй үйл ажиллагаа маш их нөлөөлж байна л гэж би бодож байна. Тэгээд миний бодож байгаа( ярьж байгаатай санал нийлж байна уу, нийлэхгүй байна уу? Нийлэхгүй бол яагаад гэдгээ нэг хэлчхээч.

**Б.Энхбаяр:** Онончимэг дарга хариулъя, 4 номерын микрофон.

**Р.Онончимэг:** Гишүүний асуултад хариулъя. Эхнээс нь шүүхийн хараат бус байдалтай холбоотойгоор асуулт асууж байх шиг байна. Үндсэн шүүхийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг бол шүүгч хэрэгжүүлдэг байгаа. ШЕЗ бол шүүхийн захиргааны дээд байгууллага буюу хараат бус, бие даасан хуульчдаас шүүгчийг шилж олох ийм үндсэн чиг үүргийг хэрэгжүүлдэг. Бид ажил аваад нэлээдгүй бас судалгаанууд хийж ажиллалаа. Илүүтэй хараат бус байдал хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хугацаандаа шийдэгдэхгүй байгаа эд нар эд нар байдал бол дандаа ар талдаа төсөв, эдийн засгийн баталгаатай холбогдож байна. Нэг талдаа шүүх өөрөө эрх мэдэл боловчиг нөгөө талдаа шүүх үйлчилгээний байгууллага. Гэтэл улсын хэмжээнд нэг ширхэг стандарт хангасан ийм шүүхийн байргүй нөхцөл байдлууд байна. Тэгэхээр илүүтэй бид нар шүүхийг стандарт хангасан байртай болгох, цахимжуулах, ил тод нээлттэй байлгах чиглэлээр төсвүүдээ орж тавьж орж ирсэн байгаа. Тэгэхээр энэ байдал дээр бас ХЗБХ дэмжиж ажиллаж байгаад бас талархаж байна.

2 дугаарт нэр дэвшигч хэдэд эрэмбэлэгдсэн бэ гэдэг асуултыг асуулаа. 2022 оны сонгон шалгаруулалтаар нэр дэвшигч Батзориг бол 2 дугаарт эрэмбэлэгдсэн байгаа. Эхний нэр дэвшигч бол Батчимэг нэр дэвшигч байсан. Улсын юу Ерөнхийлөгч рүү бол 2 удаа танилцуулагдсан. 2023 оны тухайд бол 2 бас нэр дэвшигч орж ирсэн. Тэрний эхний эрэмбэлэгдсэн нь бол нөөцийн оноогоор Батзориг нэр дэвшиж байгаа. 2-т нь бол Золзаяа шүүгч 76,71 гэсэн ийм оноогоор эрэмбэлэгдсэн явж байгаа. Тэгээд хуулиараа бол 1 дүгээрт эрэмбэлэгдсэн нэр дэвшигчийг бид нар танилцуулах ийм үүрэгтэй.

Хөгжлийн банкны тухайд бол ямар нэгэн байдлаар тухайн хэргийг шийдүүлэх

гээд ийш нь тийш нь шилжүүлдэг, сэлгэдэг ийм зохицуулалт бол байх боломжгүй болсон байгаа. Тэгэхээр тухайн дүүргийн шүүх нь нийт шүүгчдийнхээ зөвлөгөөнөөр тэр хуралдаанаа хийсэн байх гэж би хариулмаар байна. Энэ бол би шууд хариулах тийм эрх хэмжээний асуудал биш байна л гэж хэлмээр байна. Баярлалаа.

**Б.Энхбаяр:** Нэр дэвшигч Батзориг, нэг асуулт асуусан. Ганбат гишүүний асуултад хариулъя, 5 номерын микрофон.

**Н.Батзориг:** ХЗБХ-ны дарга, эрхэм гишүүдэд энэ өдрийн мэнд хүргэе. Ганбат гишүүний асуултад хариулъя. Шүүхэд итгэх иргэдийн итгэл суларсантай холбоотой ямар байр суурьтай байна вэ гэсэн ийм асуулт байна гэж ойлголоо. Олон түмний итгэл гэдэг бол шүүхийн нэр хүндтэй холбоотой. Энэ иргэдийн шүүхэд итгэл, итгэх итгэл буурсантай холбоотойгоор энэ судалгаанууд бол хийгдсэн байдаг юм байна. Нээлттэй нийгэм форум, Иргэний оюуны инновац ТББ-аас 2021, 2022 онуудад судалгаа хийсэн. Энийг бол энэ судалгаагаар бол 51 хувь, 53 хувьтай ингэж гарсан байдаг юм байна. Ер нь бол иргэний хэргийн шүүхийн хувьд бол жилдээ бол 60-аас 80 мянган хэрэг шийдвэрлэдэг. Давж заалдах шатын шүүхийн ийм Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатын шүүхийн хувьд бол жилдээ 2300-аас 2500 хэрэг шийдвэрлэдэг. Ингээд олон нийтийн анхаарал татсан 1, 2 хэргийг ингээд буруу зөрүү шийдвэрлэсэнтэй буруу шийдвэрлэсэнтэй холбоотойгоор иргэдийн шүүхэд итгэх итгэл ингэж буурч байдаг.

Тэгэхээр энэ бол иргэдийн шүүхэд итгэл маш хэврэг гэсэн үг. Ер нь бол шүүхийн тухай шинэчлэн батлагдсан хуулиар шүүх гаргасан шийдвэрээ бол тайлбарлаж байх ийм үүрэг үүрэгжүүлсэн ийм заалт орсон. Энэ дагуу

бол шүүхийн шийдвэрийн үндэслэлийг бол тодорхой тайлбарлах бичгээр болон амаар тайлбарлах энэ дээр шүүхийн шийдвэрийн хураангуйгаар олон түмэнд гаргасан шийдвэрийнхээ үндэслэлийг бол тайлбарлаж байх ёстой. Энэ дагуу бол шийдвэрийн хураангуйг бол байнга тогтмол гаргаж байгаа. Энэ бол шүүхэд итгэх итгэлийн, иргэдийн итгэлийг сэргээхэд бас ач холбогдолтой гэж үзэж байгаа. Нөгөө талаар бол иргэдийн иргэдэд хүрснээр шүүхээр асуудал шийдвэрлэгдсэнээр юуг хориглож байгаа юм, юуг зөвшөөрч байгаа юм бэ гэдгийг бол иргэд ойлгож, ажил амьдралаа зохицуулахад нь бол энэ шүүхийн шийдвэр бол туслах ёстой гэсэн ийм байр суурьтай байдаг.

Гэхдээ шүүгч хүн бол нэг үхрийн эвэр доргихоор мянган үхрийн эвэр доргино гэсэн энэ зарчмыг бол шүүхэд үйлчилдгийг бол ямагт санаж явах ёстой. Миний хувьд бол хараат бусаар ажиллаж ирсэн, цаашидаа ч энэ чиглэлээр Дээд шүүхэд ажиллаад энэ дагуу л ажиллана, энэ зарчмаа баримталж ажиллана л гэж бодож байна. Баярлалаа.

**Б.Энхбаяр:** Сандаг-Очир гишүүн асуултаа асууя.

**Ц.Сандаг-Очир:** Дээд шүүхийн шүүгчийн нэр дэвшигчдэд тавигдах шалгуур шаардлагыг хангаж байгаа юм байна, нэр дэвшигч бас орон нутагт ажилласан юм байна. Анхан болон давах шатад бас ажилласан юм байна, 16, 7 жил бас шүүхийн салбартаа ажилласан юм байна. Нэр дэвшигчээс бол нэг их асуугаад байх зүйл алга.

ШЕЗ-өөс асууя. Энэ ер нь 3 шатын шүүхийн шүүгч нарын орон тоо ер нь хэр орон тоогоороо ажиллаж байна вэ? Бид нар яагаад ингэж асууж байна гэхээр хавар Хан-Уул, Баянзүрхээр явсан, шүүхийн үйл ажиллагаатай шүүгч нартай уулзалдсан. Тэр шүүгч нар их гайхаж байсан шүү. Ер нь бараг сүүлийн арваад жил энэ хууль батлах төрийн дээд

байгууллага Их Хурлаас ингээж шүүгч нартай, шүүхийн үйл ажиллагаатай танилцаж байсан түүх байхгүй. Бас өнөөдөр ингээд манай өрөөнд ороод ирдэг юм байна гээд Их Хурлын гишүүдийг их гайхсан янзаар харж байсан.

Тийм учраас тэд нарын зүгээр ярианаас юу анзаарсан бэ гэхээр ер нь бол шүүгчээр ажиллах сонирхолтой шүүгчийн орон тоо их сул орон тоонууд олон байгаа. Хүсэл сонирхолтой шүүгч нар их ховор болсон. Тэнд үнэхээр нэг мэргэжилдээ нэг үнэнч ингээд нэг ажиллая гэсэн сэтгэлтэй хэдэн хүмүүс л үлдсэн. Тэрнээс бол ер нь ажлын ачаалал 2, 3 дахин их ийм орчин нөхцөлд, ажлын ажиллах орчин нөхцөл үнэхээр маш хүнд ийм л орчинд ажиллаж байна гэдэг ийм зүйлүүдийг ярьж байсан. Тэгэхээр Онончимэг дарга бол энэ Дээд шүүхэд, хяналтын шатад, анхан шатад энэ шүүгч нарын орон тоо ер нь хэр хангагдаж байна вэ? Хаана, ямар орон тоонууд сул байна вэ вэ? Энэ сул орон тоо хангагдахгүй байгааг юу гэж ойлгож байгаа вэ? Нийгмийн асуудалтай нь холбож ойлгож байгаа юу, ажлын ачаалалтай холбож ойлгож байгаа юу, хараат бус байдалтай нь холбож ойлгож байгаа юу энэ тэр гээд энэ тал дээр та нэг хариулт өгөөч.

Нөгөө талаар бас шүүгч нартай ярьж байхад бас ер нь бас Шүүхийн хуулиар батлагдаад 2 орчим жил болж байна, 2 гаруй жил. Сүүлийн үед бас шүүгч нар ер нь энэ Сахилгын хороон дээр их дуудагддаг, маш их дарамттай болсон гэдэг асуудлыг ярьж байна. Юм л бол болсон, болоогүй гомдол өгчихдөг. Ингээд л Сахилгын хороон дээр дуудагддаг, үүдэнд нь очоод байцаагддаг, бөөн цаг авдаг, ажлаа ч хийж чаддаггүй ийм байдалтай. Тэгэхээр ер нь энэ батлагдсан хуулиар энэ Сахилгын хорооны дүгнэлт гаргадаг энэ байдлыг ер нь хэр зөв гэж үзэж байна вэ? Засаж, залруулах зүйл байна уу үгүй юу? Энийг та юу гэж үзэж байна вэ гэдэг энэ дээр нэг хариулт өгөөч.

Батзориг нэр дэвшигчээс бол нэг асуулт асууя. Энэ Шүүхийн тухай хууль батлагдаад 2 орчим жил болж байна. Ер нь энэ шүүхийн салбарын шинэчлэл, цаашидаа улам эрчимжүүлэх, гүнзгийрүүлэхэд ер нь энэ хууль шинээр батлагдсан хууль, хэр цоорхойтой хууль батлагдсан байна вэ? Хэр бид нар шахааж баталж чадсан байна вэ? Сайн хууль гарсан гэж үзэж байгаа юу? Хаанаа цоорхойтой байна гэж үзэж байна вэ? Та яг амьдрал дээр, анхан шатан дээр, дунд шатан дээр ажиллаж байгаа хүний хувьд. Цаашидаа засаж залруулах юмнууд юу байна гэж үзэж байна вэ? Хувь шүүгчийн хувьд. Танай иргэний хэргийн асуудал бол маш их чухал юм байна лээ. Үндсэндээ бараг 3 сая иргэний чинь бараг 1 сая орчим иргэн нь иргэний хэргийн маргаан дээр асуудлаа шийдүүлдэг гэсэн статистик тоо байна лээ. Гэтэл бид нар ерөөсөө шүүхийн салбар ярихаар дандаа эрүүгийн талаас нь харж байдаг. Баахан л эрүүгийн гэмт хэрэгтнүүдийн асуудал яриад байдаг. Гэтэл захиргаа болоод иргэний асуудлын маргаантай улсууд нь дийлэнх.../минут дуусав/

**Б.Энхбаяр:** Сандаг-Очир гишүүн нэмж асууя.

**Ц.Сандаг-Очир:** Тийм учраас хамгийн их ачаалал авч байгаа энэ захиргаа иргэний хэргийн маргааны энэ шүүхийн ажиллах орчин нөхцөлүүд үнэхээр хүнд, орон тоо цөөхөн, авдаг цалин мөнгө багатай гэдэг ийм зовлон бэрхшээлүүдийг бид нар бол ярихаас илүүтэйгээр бас нүдээр очиж харсан. Та ч өөрөө хамт явж байсан. Тэгэхээр ирэх жилийн төсөв ингээд өргөн баригдчихаад явж байна. Бид бүхний ярьсан хаврын ярьсан зүйлүүд маань төсөв төлөвлөгөөнд хэр тусгаад явж байгаа вэ? Та бүхэн санал юмнуудаа хэр ирүүлсэн энэ дээр нэг бас нэг та Онончимэг дарга нэг саналаа хэлээдхээч гэж. Баярлалаа.

**Б.Энхбаяр:** Онончимэг дарга хариулъя, 4 номерын микрофон.



**Р.Онончимэг:** Сандаг-Очир гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар 516 шүүх анхан болон давж заалдах хяналтын шатанд ажиллаж байна. 2023 оны байдлаар бол 560 шүүгчтэй байх цалингийн сан батлагдсан. Улсын Их Хурлын тогтоолоор бол 699 шүүгчтэй байхаар ийм тоо тогтоосон байдаг. Нийслэлд бол ер нь орон тоо одоо бол 53 орон тоон дээр сонгон шалгаруулалт зарлаад бүртгэл ер нь дуусах, өнөөдөр яг бүртгэл дуусах өдөр байна. Тэгээд ерөнхийдөө бүртгүүлж байгаа хүмүүс маань харьцангуй бага байна.

Нөгөө талаасаа бүртгүүлээд байгаа хүмүүсийн маань тэнцлийн хувь их багатай байна. Дунджаар 15 хувьтай байна. Тэгэхээр энэний шалтгаан нөхцөлийг бол нэг талаасаа шүүгч нарын ачаалалтай холбоотой. Мөн цалингийн эдийн засгийн асуудалтай холбоотой, мөн ажиллах орчин нөхцөлтэй холбоотой байна гэж бид нар дүгнэж харж байгаа. Тэгэхээр ачааллыг бол Шүүх байгуулах тухай хуулиар, ажиллах орчныг ч гэсэн бас Шүүх байгуулах тухай хууль болон төсвийн хуулиудаар энийг үе шаттай ишийдэх байх гэж бодож бид нар төлөвлөгөөнүүдээ Их Хуралд танилцуулж байна. Шүүгчийн цалингийн судалгааг бол бас сая сүүлд хийсэн макро эдийн засгийн түвшин бол 2 дахин нугаларсан унасан ийм өөрчлөлттэй үзүүлсэн ийм судалгаа гарсан. Тэгээд энэ асуудал бас мэдээж Их Хуралд бас танилцуулагдах байх гэж бодож байна.

Шүүгчийн цалинтай юу шүүгчийн нөгөө Сахилгын хороотой холбоотой асуултад бол яг шүүгч өөрөө хүсэлт гаргавал Ерөнхий зөвлөлийн зүгээс бол итгэмжилсэн төлөөлөгчөөр оролцох ийм зохицуулалтууд байгаа. Яг Сахилгын хороотой холбоотой шүүгчийн эрх, үүрэгтэй холбоотой асуудал дээр бол шүүгч өөрөө төлөөлөд явж байгаа. Тэгэхээр Сахилгын хорооны асуудлыг зөв буруу гэж хэлэх ийм боломж байхгүй гэж бодож байна.

2024 оны төсвийг бол 6 сард ХЗБХ сайн хянаж өгсөн. Сая өнгөрсөн 5 дахь өдөр Засгийн газраас бол Их Хурал руу төсөв өргөн барилаа. Тэгэхээр хөрөнгө оруулалтын төсөв бол яг хянасан байдлаар бол орж ирж чадаагүй. Энэ бас нөгөө Шүүхийн тухай хууль зөрчигдөх нөхцөл байдал бас үүсэж байна. Тэгэхээр төсвийн асуудал ярихад бол бас ХЗБХ энэ дээр дэмжиж ажиллах, дэмжиж ажиллана байх гэж бодож байна. Баярлалаа.

**Б.Энхбаяр:** Нэр дэвшигч Батзориг шүүгч хариулъя, 5 номерын микрофон.

**Н.Батзориг:** Шүүхийн тухай хууль шинэчлэн батлагдсан. Энэ хуулиар бол шүүгчдэд дотоод ардчиллыг бэхжүүлэх, өөрөө удирдах ёсыг хэрэгжүүлэх ийм боломжийг олгосон. Үүнтэй холбоотойгоор бол Үндсэн хуулийн байгууллага болох ШЕЗ-ийн гишүүн, Сахилгын хорооны гишүүнийг шүүгчид өөрсдөө сонгуулийн зарчмаар томилдог болсон. Ерөнхий шүүгчээ бас дотроосоо сонгож томилдог гэх зэргээр дэвшилттэй зохицуулалтууд бол орсон.

Мөн шүүгчийн сахилга хариуцлагыг дээшлүүлэхтэй холбоотой сахилгын зөрчил үйлдлүүдийг бол хуульчлан тогтоосон. Энэ шүүхийн шинэчлэн батлагдсан хуулиар бол цоорхой байна уу гэж гишүүн асуулаа. Сая нийт шүүгчдийн чуулган боллоо. 2 жил тутам зохиогддог. Энэ чуулганаар бол хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой саналыг Улсын дээд шүүхэд уламжлах ийм бүрэн эрхийг нийт шүүгчдийн чуулган хэрэгжүүлдэг. Энэ дээр бол тодорхой саналууд гарсан. Ялангуяа бол шүүхийн шийдвэрийн үндэслэл рүү бол энэ Сахилгын хорооны ажил бол чиглэж байна. Энэ нь өөрөө бол шүүхийн хараат бус байдалд нөлөөлж байна гэсэн ийм агуулгаар бол бас хууль тогтоомжийг боловсронгуй болгохтой холбоотой тодорхой саналуудыг гаргаж хүргүүлэхээр тогтсон байгаа.

**Б.Энхбаяр:** Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа. Үг хэлэх гишүүд нэрсээ өгнө үү. Сандаг-Очир гишүүнээр тасаллаа. Би бас нэг үг хэлнэ. Сандаг-Очир гишүүн үгээ хэлье.

**Ц.Сандаг-Очир:** Ончимэг дарга удахгүй энэ намрын чуулганаар хэлэлцэх асуудалд манай Байнгын хороон дээр Шүүх байгуулах тухай хууль орж ирэх байх. Та бүхэн бас саналаа өгсөн гэж сонсогдож байсан. Тэгээд 2 жилийн өмнө батлагдсан Шүүхийн тухай хуулиар бид бүхэн аль болох шүүхийн үйлчилгээг иргэнд ойрхон байлгах гол агуулга зорилготой хууль батлагдсан гэж ойлгож байгаа. Гэтэл одоо өргөн баригдсан байгаа Шүүх байгуулах тухай хуулийн төслөөр бол энэ зарчмаасаа гажсаад харин ч иргэдэд шүүхийн үйлчилгээ холдох, чирэгдэлтэй байх ийм тойргийн хуваарилалт юмнууд ингэж зарим орон нутгууд дээр ингэж хуваарилагдсан байна лээ шүү. Төлөвлөгдөж орж ирсэн байна лээ шүү. Энийгээ Хууль зүйн яамтай яриарай.

Тухайлбал одоо болж байгаа шүүхийн энэ тойрог хуваарилалтыг жишээ нь алслагдсан 3 дүүрэг гэхэд Налайх дээр төвтэй, тэгээд Багануурыг яах юм бэ, Багануурын шүүхийг татан буулгах юм уу. Тэгээд Багануурын иргэд наашаагаа шүүхийн үйлчилгээ авах гэж Налайх дээр ирэх юм уу? Тэгвэл Багануурын шүүхийг татан буулгаад байр савыг нь яах юм бэ, Налайх дээр шүүгч нарыг нь байршуулах юм уу? Ингээд энийг дагаад нөгөө шүүхийн үйлчилгээ авах иргэдийн чинь зардал чирэгдэл маш хүндрэлтэй байдалд, эргэлзээтэй байдалд орж байна. Тийм учраас энэ 3 дүүргийн шүүгч нарын шүүгч нар тойргоос сонгогдсон гишүүд бид Амарсайхан гишүүн бид 2-т албан ёсоор асуудлуудаа тавьж байгаа юм. Энэ бол эргээд маш хүндрэлтэй байдлыг бий болгохоор байна. Энэ өргөн баригдсан хуулийн төсөл чинь танай веб сайт дээр тавигдсан байсан эндээс харахад.

Тийм учраас та бүхэн бас энэ санал юмаа Хууль зүйн яамтай ярьж, энэ хууль өргөн баригдаад ингээд Их Хурал дээр хэлэлцэгдэх, Байнгын хороон дээр хэлэлцэгдэх үед бол бас энэ дээр анхаарч ажиллахгүй бол энэ зөвхөн гишүүний асуудал биш. Энэ зөвхөн бас ШЕЗ-ийн асуудал биш. Энэ бас зөвхөн хууль зүйн асуудал, Хууль зүйн байнгын хорооны асуудал биш яамны асуудал биш, цаана нь ард иргэдийн энэ 3 дүүргийн ард иргэдийн асуудал. Бас Ховд аймаг бас нэг ийм чирэгдэлтэй асуудал үүссэн байна гэдэг энэ, нэг хэд хэдэн орон нутгууд дээр бас ийм асуудал гарах юм шиг надад санагдаж байна лээ. Тийм учраас энэ Шүүх байгуулах тухай хуулийн саналыг бас та бүхэнд тойрог хуваарилалтыг бас эргэж харах өргөн баригдсан хуулийн төслөө энэ дээр бас анхаарч өгөөрэй гэдгийг бас би зориуд хэлье.

**Б.Энхбаяр:** Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Намсрайн Батзоригтой Байнгын хороо танилцаж байна. Ингэснээр бас Улсын Дээд шүүх бүрэн орон тоогоороо ажиллахад бас алхам алхмаар ойртож байна. Олон орон тоо дутуу ажиллаж байгаа. Энэ нь шүүх хуралдаан шүүхийн бас үйл ажиллагаанд нөлөөлж таарна. Энэ нөлөөллийн нэг нь ШЕЗ-тэй холбоотой асуудал байна уу гэж би бас хараад байгаа. Шүүхийн тухай хууль батлагдаад 2 жил болоод хэрэгжээд явж байна. Шүүхийн тухай хуульд заасны дагуу Монгол Улсын Үндсэн хуулийн байгууллага болох ШЕЗ болон Шүүхийн сахилгын хороод байгуулагдсан. ШЕЗ 10 гишүүнтэй үүнээс тавыг нийт шүүгчдийн хуралдаанаасаа шүүгчид өөрсдөө сонгож байгаа. Энэ тавынх нь нэг нь Улсын Дээд шүүхийн шүүхээс, мөн Шүүхийн сахилгын хорооны гишүүний нэг шүүгчийг гишүүнийг мөн Улсын дээд шүүхээс сонгож байгаа юм нэр дэвшүүлж.

Шүүхийн тухай хууль хэрэгжсэнээр 2 жилийн хугацаанд Улсын дээд шүүхээс ШЕЗ-ийн гишүүнээр нэг

шүүгч, Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр нэг шүүгч сонгогдож ажиллаж байгаа. Гэтэл энэ орон тоонд нь яагаад шинээр сонгон шалгаруулалт зарлахгүй байна вэ гэдэг асуудал. Энэ орон тоог нөхөхгүй байна вэ гэдэг асуудал үүсээд байна. Улсын Дээд шүүхийн шүүгчээр ажиллаж байгаад ШЕЗ-ийн гишүүнээр томилогдож байгаа эсвэл Шүүхийн сахилгын хорооны гишүүнээр томилогдсон хүн бол одоо Улсын дээд шүүхийн шүүгч биш гэсэн үг. Монгол Улсын Үндсэн хуулийн цоо шинэ байгууллагын гишүүн болчихсон аль эрт. Тэр хүний ингээд ажлыг нь хадгалаад, орон тоог нь зарлахгүй байна гэдэг шүүхийн Дээд шүүхийн үйл ажиллагаанд нөлөөлнө. Нөгөө хүмүүстэй бол сайхан байж магадгүй. Тэгэхдээ энэ чинь 2 газар хөлөө тавьчхаад сууна гэж бүүр байхгүй шүү дээ. Тэр тусмаа 6 жилийн хугацаагаар ажиллах Үндсэн хуулийн байгууллагын гишүүнээр томилогдчихсон байгаа байхгүй юу.

Тийм учраас энэ Улсын дээд шүүхийн шүүгчдийн юу ШЕЗ болон Шүүхийн сахилгын хорооны гишүүдээр томилогдсон энэ шүүгч гишүүдийн сул орон тоог зарлаж, яаралтай нөхөх арга хэмжээ авах хэрэгтэй байна. Өөрөөр хэлбэл хуулийг хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Энэ дээр бас анхаараарай гэж би

бас протоколд тэмдэглүүлж, ШЕЗ-ийн даргаар уламжлуулаад нийт ШЕЗ-ийн гишүүдэд хэлж байгаа юм. Тэгэхгүй ингээд 6 жил би миний ажил түр томилогдсон гэж байгаа юм уу, зарлахгүй ингээд байгаад байж болохгүй. Хэрвээ шүүгч гишүүд өөрсдөө тийм бүлэглэл үүсгээд, кнопны хүчээрээ энэ асуудлыг шийдэхгүй байгаа бол Улсын Их Хурал хууль тогтоогч хуульд бас өөрчлөлт оруулж болно. Хуульд өөрчлөлт оруулчхаж болно. Ийм зүйлийг бас хэлмээр байна.

Ингээд нэр дэвшигчдээ хуульд, Монгол Улсын Дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигч Намсрайн Батзориг шүүгчтэй Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороо танилцаж дууслаа. Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Сандаг-Очир гишүүн танилцуулах уу? Багануур дүүргээс ажил, амьдралын гараагаа эхэлсэн шүүгч байна шүү дээ. Сандаг-Очир гишүүн танилцуулъя.

11.29 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ  
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ  
БУУЛГАЖ, ХЯНАСАН:  
ШИНЖЭЭЧ Д.УЯНГА